


## АН АЧААНЫ ХҮНДИЙГ ҮҮРЭХ НЬ ТОДОРХОЙ



Би өвдөг шороодоогүй!

Булхай!



# SMART BANK



ҮЙЛЧИЛГЭЭГ  
ТАНИЛЦУУЛЖ БАЙНА



## Смарт банк Смарт утас

- Бүх төрлийн гүйлгээ хийх
- Дансны үлдэгдэл шалгах
- Хэрэглээний төлбөр төлөх
- Салбар, АТМ-ын байршил харах
- Валютын ханш харах, хөрвүүлэх



[www.golomtbank.com](http://www.golomtbank.com)

310639

RioTinto



RioTinto

Монголын Үндэсний  
Олимпын хороо  
АЛТАН ТҮНШ



**Оюу Толгой төсөл,  
Олимпийн багийн амжилт  
Рио Тинтогийн бахархал**

[www.riotinto.com/london2012](http://www.riotinto.com/london2012)  
[www.ot.mn](http://www.ot.mn)

**уурхайн гүнээс  
аваргын энгэрт**



Ногоон хөгжлийн пөлөө

# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ВЭБ РЕДАКТОР

Б.Энхмарт

ОРЧУУЛАГЧ:

Б.Үүрийнтуяа

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь

□□□□□□□□□□:

Н.Түвшинбаяр

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖЕР:

Ж.Алтантуяа /9905-1914/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барманжав /8880-0825/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш

“ECONOMY” ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ:

Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН

Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

ÀĪĎĒÓÓĒÀŎ ÖŪĀ Ā:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall"

## MONGOLIAN ECONOMY



ЗАХИАЛГЫГ:

“Монгол шуудан”

“Түгээмэл шуудан”

“Sky” шуудан

“UB Post” шуудангийн салбарууд болон  
сэтгүүлийн редакцид авч байна.

УТАС: 7011-5476  
8880-0825  
9905-1914

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn



**Т.Чулуун: Монголоо ногоон соёл иргэншлийн өлгий нутаг болгоё**

Судлаач хүний нүдээр сүүлийн 20 жилийг эргээд харахад, Монгол Улс тогтвортой хөгжлийн түвшнээр хамгийн муу замналаар явж байна. ...16

**Цахирмаа цэцгийн диваажин**

Дэлхий нийт ногоон өнгөнд “хайр зарлах” болжээ. Ногоон бол XXI зууны бэлгэ тэмдэг. Гэхдээ энэ нь дэлхийг бүрхэх мод, өвс ногоо, ургамал цэцэгсийг хэлээгүй. Харин “ногоон” сэтгэлгээг илэрхийлж буй...20



**Л.Болормаа: Ажилтай, боловсролтой, аз жаргалтай нийгэм бүтээх нь Хөгжлийн банкны үүрэг**

Хөгжлийн банк бол хөгжлийн тасалбар. Тиймээс тасалбараа урж, үрчийлгэж болохгүй. Хүчингүй болох эрсдэл их...23

**Үндэстэн дамнасан худалдааны бизнес хүртэл**

Өдгөө 20 насныхаа ойг угтаж буй “Номин” холдинг группын үндэс суурийг ийнхүү Шагдарсүрэн гурван хүү, эхнэрийнхээ хамтын ухаанаар, өргөө гэртээ, өөрт байгаагаараа эхлүүлсэн нь энэ...40



- 8 АН ачааны хүндийг үүрэх нь тодорхой
- 12 Сонгуулийн уриа үгийн эргэн тойронд

**14 “Ногоон” Ерөнхийлөгч**

**16 Т.Чулуун: Монголоо ногоон соёл иргэншлийн өлгий нутаг болгоё**

**20 Цахирмаа цэцгийн диваажин**

**23 Л.Болормаа: Ажилтай, боловсролтой, аз жаргалтай нийгэм бүтээх нь Хөгжлийн банкны үүрэг**

**28 Азийн хөгжлийн загвараас бидэнд сурах зүйл бий юү**

**29 Монголчууд махны бизнесээс өндөр ашиг хүртэх боломжтой**

**32 Монголын нүүрсэнд ирээдүй бий юү**

**36 90+...**

**38 Брэндтэй бол бурханаас гуйх юмгүй**

**40 Компанийн түүх**

**43 Харшил дэлхий нийтийн өвчин болж байна**



**Монгол Улсын**

Засгийн газар иргэддээ “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 1072 ширхэг хувьцаанаас гадна “Эрдэнэс МГЛ” компанийн давуу эрхийн нэг ширхэг хувьцааг нэмж олгохоор шийдвэрлэлээ. Дээрх шийдвэрийн дагуу иргэд стратегийн ач холбогдол бүхий орд газруудаас насан туршдаа ногдол ашиг хүртэх эрхтэй боллоо. Энэ нь Монгол Улсын иргэд Засгийн газар, хувь нийлүүлэгчдээс түрүүлж хувьцааныхаа ногдол ашгийг хүртэх боломжтой гэсэн үг. “Эрдэнэс МГЛ” компани нь 100 сая ширхэг энгийн, гурван сая ширхэг давуу эрхийн хувьцаа эзэмшдэг. Тэгэхээр хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй иргэн бүр нэг ширхэг давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй болж байна. Эл хувьцааг худалдах, арилжих,

бэлэглэх, барьцаалах, өв залгамжлах нь хуулиар хориотой. Мөн тухайн хүн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмших эрх нь дуусгавар болох ажээ.

**Төв аймгийн** Хөшигийн

хөндийд баригдах нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн төлөвлөгөөг Засгийн газраас баталлаа. Онгоцны шинэ буудал байгуулах ажил одоо үргэлжилж байгаа бөгөөд 2015 онд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Шинэхэн буудалтай болсноор зургаан онгоц зэрэг хүлээн авч, жилд нэг сая 650 мянга гаруй хүнд үйлчлэх боломж бүрдэх аж. Түүнчлэн тэнд ажиллах хүмүүст тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор буудлыг түшиглэн 100 мянган хүн амтай хот шинээр байгуулахаар болжээ. Шинэ хот нь аялал жуулчлал, хүнс, хөнгөн үйлдвэр, сэргээгдэх эрчим хүч, мэдээлэл технологид тулгуурласан хөгжлийн үндсэн чиглэлтэй, газар тариалан, мал аж ахуй, мах, махан бүтээгдэхүүн, барилгын материалын

үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцээр найдвартай хангагдсан хот болох аж.

Засгийн газраас нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 15 мянга, 18 ба түүнээс дээш насны хүнд сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 10 мянган төгрөгөөр тогтоолоо. Энэ тэтгэмжид 80 мянган өрх хамрагдах бөгөөд ирэх долдугаар сараас олгох юм.


**Манай улс** өнгөрсөн

хавар 15 сая төл хүлээн авснаар нийт малын тоо толгой 50 саяд хүрсэн байна. Тиймээс мал аж ахуйг дагасан хөгжил, малын бэлчээр, отор, малчдад зориулсан зээл, халамжийн үйлчилгээг сайжруулах нь нэн тэргүүний ажил гэдгийг ХХААХҮ-ийн сайд онцлон ярьжээ.

**“Сайншанд” аж**

үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөг өнгөрсөн сарын 25-нд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Мастер төлөвлөгөө болон цогцолборын бүтээн байгуулалтыг удирдан хэрэгжүүлэх, төслийн өдөр тутмын ажлыг хариуцах үүрэг бүхий төрийн өмчит “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор компанийг хамтад нь байгуулахаар боллоо. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөг 12 хэсэгт хуваан боловсруулсан байна. Төлөвлөгөөний дагуу кокс, зэс хайлах, үрлэн төмөр, цементийн үйлдвэр байгуулах бөгөөд жилдээ 12 сая тонн түүхий эд, материал, долоон сая гаруй тонн боловсруулсан бүтээгдэхүүний тээвэрлэлт хийх учир ачаа тээврийн иж бүрэн байгууламж ч барих аж. Энэхүү бүтээн байгуулалтын шатанд 10 мянга гаруй ажлын байр бий болох бол ашиглалтын шатанд 2400 гаруй тогтмол ажлын байр, түүнийг дагалдан 21 мянган хүнтэй суурьшлын шинэ бүс үүсч, 7300 айлын орон сууц, долоон лаборатори, нэг эмнэлэг, таван цэцэрлэг барих юм байна. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборыг байгуулахад ойролцоогоор

Монгол Улсын ДНБ-ий өсөлтийн таамаг 2011, 2012 /хувиар/



2011-2012 оны ДНБ-ий өсөлтийн таамаг /хувиар/

	Дэлхий		АНУ		Евро бүс		Хятад	
	2011	2012	2011	2012	2011	2012	2011	2012
<b>ОУВС</b>	3.6	4	1.4	2.2	1.1	1.6	9.3	9.1
<b>Дэлхийн банк</b>	3.2	3.6	2.6	2.9	1.7	1.8	9.3	8.7
<b>Fitch</b>	3	2.4	1.7	1.8	1.6	0.4	9	8.5
<b>Goldman Sachs</b>	3	3.2	1.6	2	-1.6	0.1	9.1	8.6
<b>Standard Chartered</b>	3	2.2	1.8	1.7	1.5	-1.5	9.2	8.1

Аливаа орны эдийн засаг ямар байх нь үйлдвэрлэл, гадаад худалдаа, инфляци гэх мэт тухайн орны суурь үзүүлэлтүүд, төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй бодлого, мөн хэрэглэгчийн хүлээлт, итгэл гэсэн гурван хүчин зүйлээс хамгийн ихээр хамаардаг. Харин эдийн засгийн хөгжлийн түвшинг тогтоох энгийн бөгөөд түгээмэл арга бол тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт /ДНБ/ байдаг.

9.3 тэрбум ам.доллар шаардлагатай гэсэн тооцоо гарчээ.

**Дэлхийн банкны** судалгаагаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт хурдацтай үргэлжилсээр оны эхний улирлын байдлаар 16.7 хувиар өсчээ. Эдийн засгийн өсөлтөд үйлчилгээний салбар, тухайлбал, бөөний болон жижиглэнгийн худалдаа тэргүүлэх үүрэг гүйцэтгэжээ. Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар жилийн 51 хувь, тээвэрлэлтийн салбар 11.7 хувиар өссөн байна. Харин Засгийн газрын зардлын өсөлт орлогын өсөлтөөс давж, төсвийн алдагдал нэмэгджээ.

**Манай улсын** нийт экспортод эзлэх ашигт малтмалын бүтээгдэхүүний эзлэх хувь өмнөх оны мөн үеэс таван хувиар нэмэгдэн, 94 хувьд хүрч, бусад экспортын бүтээгдэхүүний хувийн жин дөрвөн хувиар буурчээ. Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох дөрвөн түүхий эдийн экспорт нь ашигт малтмалын экспортын 91 хувийг бүрдүүлж, нийт экспортын 84 хувийг эзэлсэн байна. Харин ноос, ноолууран бүтээгдэхүүний экспорт 26 хувиар буурчээ. Энэ нь нийт экспортын өсөлтийг 3.4 хувиар бууруулсан хэмээн Монголбанкны гадаад худалдааны тоймд тэмдэглэжээ.

**Дэлхийн банкнаас**

Орос улсын хэмжээнд хийсэн судалгаагаар тус улсын голлох 30 хотоос бизнесийн үйл ажиллагаа явуулахад хамгийн хүндрэлтэй хотоор Москва тодорчээ. Энэхүү үнэлгээ нь компаниудын өмнө тулгарч байгаа саад бэрхшээлийг улам цөөлнө хэмээн амлаж байсан тус хотын захирагч Сергей Собянинийг нэлээд хүнд байдалд оруулжээ. Мөн өнгөрсөн оны аравдугаар сард нийт арван үзүүлэлтийг харгалзан гаргадаг дэлхийн улс орнуудын “Бизнес эрхлэлт”-ийн тайланд ОХУ бизнес эрхлэлтийн орчноороо 183 орноос 120 дугаарт эрэмблэгдсэн байна. Харин 2005 оноос хойш тус улс асуудлыг шийдвэрлэх зорилгоор бизнест ээлтэй хууль тогтоомж олноор батлах болсноор хамгийн хурдан

хугацаанд нөхцөл байдлаа сайжруулж буй 30 орны тоонд багтсан таатай мэдээ байна.


**Хятад улс** хувиараа

хөрөнгө оруулагчдад банкны системээ нээлттэй болгожээ. Энэ нь Бээжингээс эдийн засгийн өсөлтөө тогтвортой авч явах хамгийн сүүлийн арга хэмжээ аж. Амралтын өдрүүдэд, Хятадын зүгээс хувиараа хөрөнгө оруулагчид болон төрийн компаниуд дотоодын банкинд хөрөнгө оруулах асуудал дээр ижил тэгш эрхтэй байх ёстой хэмээн мэдэгдсэн юм. Хятадын эдийн засгийн хүчтэй өсөлтийг үл харгалзан шүүмжлэгчид ашиггүй банкны салбар их өсөлтөд дарамт болно гэж үзэж байна. Хятад улс саяхан харилцаа холбоо, эрчим хүчний салбараа нээлттэй болгоод байсан билээ.



Гадаадын шинэ хөрөнгө оруулалтыг татах энэ арга нь манай урд хөршид сэргээш болж, эдийн засгийн хөгжлийн өрнөлөө алдалгүй цааш авч явна гэж найдаж байна.

Хятадын банкууд жижиг, дунд үйлдвэрлэлд зээл олгодог байсан бол одооноос хувийн салбарынхан үнэт цаас шилжүүлэх, байршуулах, захиалах, нэгтгэх, худалдан авах гэх мэт банкны үйл ажиллагаанд шууд оролцох нөхцөл бүрдэж байна. Түүнчлэн банкны шинэ систем нь хууль бус, хориотой зээлийн арга хэлбэрүүд багасахад сайн нөлөө үзүүлнэ гэж албаныхан үзэж байгаа аж.



УЛС ТӨР

## АН АЧААНЫ ХҮНДИЙГ ҮҮРЭХ НЬ ТОДОРХОЙ

АН бусадтай хэрхэн хэл амаа ололцож, найрсаж, хариуцлага тооцож, хамтарч ажиллахаа харуулах цаг болжээ. Иргэд шинэчлэл, өөрчлөлт, хүндээ наалдсан эдийн засгийн өсөлтийг шинэ сонголтоос хүлээж байгаа.

### Д.БЭХЭЭ

Олуулаа ялна шүү гэсэн уриа бүхий Ардчилсан нам олуулаа яллаа. Монголчууд 22 настай ардчиллыг хүндэтгэж, итгэл хүлээлгэхээр шийдсэнийг сонгуулийн дүнгээс харж болно. Гэхдээ харамсалтай нь АН засгийг дангаар бүрэлдүүлэх хэмжээнд оноо авч чадсангүй. 39 суудал авч байж, Засгийн газрыг бүрэлдүүлж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжтой болох байлаа. Тиймээс тус нам одоо өөр нам, эвслийг сонгож, хамтран ажиллах хэрэгтэй боллоо гэсэн үг. Тэрхүү азтай нам, эвсэлд МАН, МАХН-МҮДН-ын “Шударга ёс” эвсэл орж байна. Бусад нам, эвслүүд АН-тай яриа хэлэлцээр хийх хэмжээнд суудал авч чадаагүй юм. АН хуучны түнш Ардын намтай эвсвэл тэгнэ, Энхбаярын намтай найрвал ингэнэ гэсэн таамаг зураглалыг хэвлэлүүд хийж байна. Алинтай ч нэгдсэн бай АН ачааны хүндийг үүрэх нь тодорхой.

Өнгөрсөн дөрвөн жилд МАН-тай гэр бүл болсноор хожсон, бас хожигдсон ч зүйл бий хэмээн ярьж, Ардын намаас сонгуулийн өмнө гэнэтхэн салсан АН энэ удаа хуучны түншээ сонгож магадгүй гэсэн таамаглалыг улстөрчид дэвшүүлж байна. МАН-тай найрсах тохиолдолд тус намаас багагүй шаардлага тавина. Гэхдээ л нэгнийхээ занг авч, харилцан хамтран ажиллаж, туршлага суусан намууд шүү дээ. Бас хуйвалдан хамтдаа идэж уусан ч гэж ярьж байгаа. Харин “Шударга ёс” эвсэлтэй нэгдэх бол шаардлага нь бага ч нэр хүндийн асуудлуудтай тулгарна. Наад зах нь МАХН-ын дарга Энхбаярыг хамгаалах хэрэгтэй болно. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой харилцааны асуудалд орно. Мөн МАХН-ын Тавантолгой, Оюутолгойг 100 хувь иргэдийн мэдэлд өгөх сонгуулийн амлалтыг АН хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх үү гээд л хүндрэлтэй зүйлүүдтэй учирна.

Юутай ч иргэд энэ удаа ардчиллаар овоглодог



“хүүхдүүдийг” төрд гаргаад үзье гэсэн байр суурьтай сонгуульд хандсан нь илт харагдана. Харин МАН-ыг хүчтэй цөөнх болгохыг зорьжээ. Сөрөг хүчингүй Парламент ямархуу байдлаар ажиллагдийг өнгөрсөн дөрвөн жилд мэдэрсэн болохоор иргэд ийн сонголт хийхийг хүссэн хэрэг. Уг нь аль нэг нам нь үнэмлэхүй ялалт байгуулсан бол ажил нь гацахгүй явах байсан гэх нэгэн байхад харин ч хоорондоо хэлэлцэж, ярьж, маргалдаж, хэрэлдээд ч болов явбал зөв шийдвэр гаргана шүү дээ гэх хэсэг ч байна. Гэхдээ хамгийн чухал нь улс орныхоо эрх ашгийг эн тэргүүнд тавьбал бие биенийхээ ажлыг гацаанд оруулж нураагаад, өмнөх сөрөг туршлагаудыг давтах шаардлага байхгүй л баймаар санагдана. Нөгөөтэйгүүр АН-д ээлж ирдэг гэдгийн тод жишээг харууллаа. Тэд УИХ-ын танхимыг олонтаа орхин хаяж явсан дүр зургийг хүмүүс санаж байгаа. Одоо ийм байдлыг өөрсөд дээрээ туулах амаргүй даваатай тулгарахаар болж байна.

### Монголчууд гайхалтай юм аа

Сонгогчдын мэдлэг боловсролын түвшин өөр болсныг нэр дэвшигчид анзаарсан байх. Цагаан цаасан дээр юу ч яриад дийлнэ гэдэг бодлоо хаях цаг иржээ. Улс орны ▶



► хөгжлийн түүхэн гараан дээр ирсэн энэ үед ард иргэд төрийн эрх барьж байсан хоёр намд бараг л эн тэнцүүхэн сонголт хийлээ. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн олон чухал асуудлыг шийдвэрлэх энэ дөрвөн жилд МАН, АН-ыг дахин хамтран ажиллах боломжийг олгосон, өөрөөр хэлбэл, хийсэн эхлүүлсэн, хамтдаа нэр зүүсэн ажлуудаа хамтдаа дуусга, бас алдаа оноогоо хамтдаа зас, үүрээд яв гэсэн сонголт ч байж болох юм. Баярлан хөөрөхөөсөө илүүтэй маш том хариуцлага гэдгийг ухаарах ёстой. Хөл жийлцэн албан тушаалд уралдан би чи дээрээ тулаад байх уу, нэгдмэл санаа зорилгоор улс орныхоо эрх ашгийг эн тэргүүнд тавиад улс шиг хөгжүүлээд явах чадамж байна уу. Улс шиг хөгжье, хүн шиг амьдаръя хэмээн орж ирсэн мөнгийг гарын салаагаар халамж хэлбэрээр тараах системгүй бодлого явуулах уу, иргэдийг цалинтай, орлоготой болгохын төлөө зүтгэх үү гэх мэтчилэн олон асуудал асуулт хэлбэрээр хүлээж байна. Үнэндээ бол хийх, шийдэх ажил их байна.

Улс, орон, ард түмэн минь л нэгдүгээрт шүү дээ гэж гуйж, гувшиж гарчихаад сонгуулийн маргаашаас эхлэн дээгүүр харан явдаг уламжлал манайд бий. Энэхүү асуултад АН хэрхэн хариулахыг харах үлдлээ. Шархаа нөхнө гэж ярьдаг шиг зарцуулсан, гаргасан мөнгөө

хэд дахин нэмж олж авах, улсын мөнгийг хувааж идэх, завших байдлаар явбал Монголын ардчиллын ирээдүй юу болохыг АН-ынхан мэдэж байгаа гэж найдъя. Тэд МАН-ын тухай олныг хэлдэг байсан. Ажиллаж чадахгүй байна, авлига, хээл хахуулийг цэцэглүүлж байна, төрийн аппаратыг хэтэрхий нүсэр болгож байна, төрөөс төрсөн тэрбумтангуудын тоо олширч байна, ядуурал буурахгүй байна, амьдрал дээшлэхгүй байна, өсөлт хүнд наалдахгүй байна гэх мэтчилэн болохгүй, бүтэхгүй байгаагийн талаар урсган ярьдаг байсан. Өөрсдөө засгийг хамтдаа барилцаж байсан хэрнээ л ингэж ярьдаг байсан шүү дээ.

Эцэст нь тэмдэглэхэд улс төрийн соёлоортөлөвшөөгүй, маруухан гэдгээ манай намууд энэ удаагийн сонгуулиар үзүүллээ. Төлөвшсөн, 90 жилийн түүхтэй гэдэг том нам нь ч хэрхэн жижгэрч, бусад намтай хамтран хэвлэлийн хурал хийж буй дүр зургийг та анзаарсан байх. Ялагдлаа орчин үеийн шинэ техник технологи руу чихэж буй зураглал өрөвдөлтэй харагдсан шүү. Хэзээ ялсан нам нь ялсан шиг, ялагдсан нь ялагдсан шиг байж сурах юм бол доо. Мөн монголчууд хэзээ сүүлийн үеийн техниктэй харьцаж сурах, мөн түүнд итгэдэг болох юм бол. Хэрвээ АН ялагдсан бол мөнөөх тооллогын машин руу дайрах байсан болов уу. Энэхүү асуултыг асуултын тэмдэгтэй үлдээв. ■

## “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

**-УИХ-ын сонгууль болж өнгөрлөө. АН олонхийн санал авч, төр, засгийг байгуулах санал санаачилга гаргах эрхтэй боллоо. Та ямар сэтгэгдэлтэй байна вэ?**

Л.ОЮУН /МУИС-ийн багш/

-Ардчилсан нам ажлын байр бий болгох, иргэдийг тогтмол ажлын байраар хангахад түлхүү анхаарах болов уу. Эдийн засгийн өсөлтийг хадгалж үлдэх гарц бол ажлын байр. Тиймээс үйлдвэрлэлийн салбарт ажлын байр нэмэгдүүлэхэд Засгийн газрын бодлого чиглэх байх. Үүнд л найдаж байна.



Б.ТҮВШИНТӨГС

/Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төвийн захирал, эдийн засагч/

-Ардчилсан нам Засгийн газраа байгуулах эрхтэй хэдий ч ямар мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхээс хамаарч, эдийн засагт өөрчлөлт гарна. Аль нам нь ялж, ялагдах нь гол бус харин ямар эдийн засгийн эрүүл бодлогыг ирэх дөрвөн жилд хэрэгжүүлэх вэ гэдэгт л бид ач холбогдол өгөх хэрэгтэй. Одоогоор Засгийн газрын бүтэц, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр тодорхой бус учраас дүгнэж хэлэхэд эрт байна. Гэхдээ өөрчлөлт гарна байх. Ирэх жилүүдэд эдийн засагт эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс илүүтэй үйлдвэрлэлийн өсөлт эрчимжих болов уу. Учир нь, “Оюутолгой” уурхайн үйлдвэрлэл ашиглалтад орох гэж байна.



Б.БЯМБАСАЙХАН

/“Ньюком” группын гүйцэтгэх захирал/:

-Энэ удаагийн сонгууль хууль, журмынхаа дагуу болж өнгөрлөө. Монголчууд сонголтдоо хийсэн, сонголтдоо ч үнэнч байх болно гэдэгт итгэлтэй байна. Манай улсын хөгжлийн бодлого, шинэ Засгийн газар, УИХ-аар дамжин хэрэгжинэ.

Ирэх дөрвөн жил бол их бүтээн байгуулалтын жил байх болно. Тиймээс бизнесийн орчин тогтвортой байгаасай гэж хүсэж байна. Учир нь, баялгийг бүтээгч бизнесийн салбар, хувийн хэвшлийнхний амжилтын үндэс нь хөрөнгө оруулалт, санхүүгийн орчин нээлттэй, тогтвортой, ил тод байх зарчим юм.



С.ОРГОДОЛ

/Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын орлогч/

-Ардчилсан нам хувийн хэвшилд ээлтэй бодлого хэрэгжүүлнэ байх. Энэ нь бизнес эрхлэгчдэд өөрчлөлтийг авчирна. Түүнээс нийт эдийн засагт том өөрчлөлт гарахгүй болов уу. Гэхдээ ямар бодлого хэрэгжүүлэхээс эдийн засгийн хөгжил, улс орны ирээдүй шалтгаална. ►►



▶ **Б.БААБАР** /Нийтлэлч/

-Хүмүүс өөрчлөлтийг хүсээд байна. Энэ өөрчлөлт нь АН мөн үү, биш үү гэдгийг би хэлж чадахгүй. Ямар ч байсан ард түмэн Ардын намаас залхчихаад байна. Тийм учраас тэд Улаанбаатар хотод нэг ч суудал авч чадсангүй шүү дээ.



**Д.ДАМДИНБАЯР**

/МУИС-ийн Технологи Дамжуулах Төв Оюуны өмчийн асуудал хариуцсан менежер/

-Манай улс хөгжлийн гараан дээрээ байгаа энэ үед намууд олон сайхан зүйл амалж мөрийн хөтөлбөрөө гаргасан байсан. Гэхдээ одоо үүнийгээ хүнд хүрэхээр зөв менежменттэй хэрэгжүүлэх нь л чухал. Ардчилсан нам хамтарсан Засгийн газар байгуулахаас өөр сонголтгүй болоод буй. Ямар ч байсан эвсэж, нэгдээд засгийн эрхээ сайн авч явах хэрэгтэй байгаа юм. Түүнчлэн уул уурхай салбараас олж буй ашгаа мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэхэд түлхүү чиглүүлээсэй.



**Д.ДАМБА**

/Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч /

-Ирэх дөрвөн жилд АН МАН-тай хамтарч төрийн эрх барина гэж бодож байна. Өмнөх дөрвөн жилд МАН олонхи байсан бол одоо АН олонхи болж хуучин хийж байсан ажлаа үргэлжлүүлэн хийх байлгүй. Ямар ч байсан хамтран ажиллаж байсан туршлагатай намууд юм чинь бодлогоо зөв зүйтэй чиглүүлэх байх гэж найдаж байна. Нам солигдохоор төрийн албан тушаалтнуудыг халж, сольдог байдал гаргахгүй байгаасай. Ирэх жилүүдэд уул уурхайн салбар үсрэнгүй хөгжиж, эдийн засагт ихээхэн үр өгөөжөө өгнө. Тэгэхлээр уул уурхайн салбарын хөгжлийг боомилж, саад тотгор болсон хууль, тогтоомж гаргахгүй байгаасай гэж найдаж байна.



**СТИВ ПОТТЕР**

/Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК-ийн ерөнхий захирал/

-Би хувьдаа эвслийн Засгийн газар амжилттай хамтран ажиллаж, өмнөх Засгийн газрын бүтээснийг үргэлжлүүлэн, бизнесийн үйл ажиллагаа явуулах болон хөгжин дэвших илүү таатай нөхцлийг бүрдүүлнэ гэдэгт найдаж байна.

Юунд ч засаж сайжруулах зүйл үргэлж байдаг. Шинэ Засгийн газрын хувьд батлагдаад удаагүй байгаа Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхлыг тодорхой хэмжээгээр харгалзан үзэж, тусгах нь зүйтэй. Ингэснээр бизнес эрхлэгчид цаашид үр ашигтай үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын эдийн засгийн эрүүл мэндэд төдийгүй монголчуудын хүртэх нийт ашигт хувь нэмрээ оруулж чадна гэж бодож байна. ■


## ШОГЛОХУЙ

# СОНГУУЛИЙН УРИА ҮГИЙН ЭРГЭН ТОЙРОНД

Ч.ЗОЁНОО

*“ҮГ бол хоёр талдаа хурц иртэй илд юм” гэсэн нь бий. Үгээр хүнийг алж ч чадна, амьдруулж ч болно гэж ярьдаг нь үүнтэй холбоотой биз ээ. Харин энэ удаагийн сонгууль үгэн зэвсгээр тулалдсан нэг талаар хүмүүсийн элэг хөшөөсөн, нөгөө талаар бусдын үүр цухлыг барсан үйл явдал болж өнгөрлөө. Ингээд уншигч танд нам болон нэр дэвшигчид ямар ямар уриа дэвшүүлснийг хүргэе.*

Энэ удаагийн сонгуулийн хамгийн шуналтай уриагаар Ардчилсан намын “Олуулаа ялна шүү” гэх уриа тодорсон байна. Учир нь, “Олуулаа ялж байгаад цөм иднэ ээ” гэсэн сэтгэгдлийг төрүүлж байна хэмээн иргэд гомдоллосон сурагтай. Мөн “Хүн шиг амьдаръя, Улс шиг хөгжье” гэх уриа нь зарим хүнд “Одоо бид хүн шиг амьдрахгүй байгаа юм бол тэгээд юутай адилхан амьдарч байгаа юм бол” гэх эргэлзээг төрүүлээд байгаа гэнэ.



Хамгийн утгагүй бөгөөд өөрийгөө биш найзыгаа рекламдсан уриагаар МАН-аас нэр дэвшигч Б.Мөнхбаатарын сонгосон “Зам дагаж хөгжил, Цол дагаж бяра” үг шалгарлаа. Уг урианаас харахад тухайн нэр дэвшигч арслан цолтой, хүчтэй найзтай учраас намайг сонгоорой гэсэн бололтой.

МАН-ын “Эх орондоо сайхан амьдарцгаая” гэх уриа үг зарим нэгний хувьд доромжлол мэт санагдсан байна. Урьд нь “Та нар дорой амьдарч байсан. Харин намайг сонговол сайхан амьдарцгаана” гэж буй мэт. Мөн өөр нэг хувилбар нь “Нийгэмд шударга ёс, Иргэнд тэгш боломж” олгохоор зорилгоо тодорхойлов. Монгол Улсын 90 жилийн түүхийг бичдэг эл нам өнөөдрийг хүртэл иргэнд ялгавартай хандаж байжээ гэх ойлголтыг төрүүлэхүйц байна гэнэ. МАН-ын “Зугтаж биш зүтгэж, Үгүйсгэж биш бүтээж” гэх уриаг зарим хүн “Нээрээ л эд нар мөнгөний төлөө зугтаж биш зүтгэж, өөрсдийнхөө эрх ашгийг үгүйсгэж биш бүтээж байгаа даа” хэмээн өөрчилжээ.



Хамгийн мөрөөдөмтгий уриагаар энэ удаа “Төрөө МАН-АН-гаас, Түмнээ ядуурлаас гаргана” гэх уриа тодорсон байна. УИХ-ын сонгууль бүрт ийм утгатай уриаг намууд дэвшүүлдэг бөгөөд харамсалтай нь тэд иргэдээ ядуурлаас аврахаа умартаж, өөрсдийгөө л ядуурлаас гаргадаг байх даа.



21 дүгээр тойрогт нэр дэвшигч өөрийнхөө төлөө сонгогчдын өмнөөс дуугарсан байна. Зарим талаар сонгуулийн дүн гарахаас өмнө санал хураалтын дүнг зарласан хэрэгт унах вий дээ, мань хүн.





Хогийн шүүр барьсан мань эр сонгуульд ялчихвал маргаашнаас нь дүүргийнхээ хогийг шүүрдэх нь гэх сэтгэгдэл төрмөөр. Ядаж байхад хог, шороонд дарагдсан гэр хороололд нэр дэвшиж байгаа түүнийг сонгогчид шууд л ТҮК-ийн ажил хийх юм байна гээд ойлгогчихсон бололтой. Зарим нэг хөгшид “Шүүр барьчихаад төр удирдана гэнэ. Эр хүний сүлд хийморьт муугаар нөлөөлөх байгаа даа” хэмээн халаглаж зогссон гэнэ шүү.

Хотоор дүүрэн хотын дарга. Хаа сайгүй түүний зурагтай самбар харагдана. Зарим гишүүн самбаргүй хэцүүдэж байхад манай хүн ч дарга гэдгээ харуулаад авсаан.



УИХ-ын сонгуульд яруу найргийн өнгө аяс оруулж ирсэн уриагаар “Эгэл түмний Уянга, Эрх баригчдын аянга” тодорсон аж. Зарим талаар түүний авахуулсан зураг 1980-аад оны гал улаан бүчтэй зурагчдыг санагдуулна.



Ямартай ч нэр дэвшигчид үгэн зэвсгээр энэ мэт хайр гамгүй үзэлцсэн юм. Харин гаднын нэр дэвшигчид төвч бөгөөд тодорхой, аль болох дам бөгөөд давхар санаа агуулаагүй уриа үг сонгодог аж. Тухайлбал, Н.Саркози “Хүчирхэг Франц улс”, Барак Обама “Урагшаа” гэх мэт сонгуулийн уриатайгаар энэ удаагийн сонгуульд нэрээ дэвшүүлсэн аж.

Манайхны хувьд бүтэн шад шүлэг бичих нь холгүй,



Баянгол дүүрэгт МАН-аас нэр дэвшиж буй Л.Амгалан бүсгүй “Иргэн амгалан бол нийгэм амгалан” хэмээх үгийг гудамжаар дүүрэн тавьжээ. Хэрэв түүний нэр Сандруу байсан бол бүр балрах нь ээ. Мөн Иргэний хөдөлгөөний намаас дэвшигч Д.Үүрцайх “Монголын төрд үүр цайлгая” гэжээ. Түүнчлэн нэр дэвшигч Н.Батцэцэг “Та ээждээ итгэдэг бол эмэгтэй нэр дэвшигч надад мөн итгээрэй” гэсэн байна. Түүнд ганцхан ээждээ итгэдэг хүн л саналаа өгөх учиртай юм бол аавдаа, эсвэл хоёуланд нь итгэдэг хүн саналаа өгч болохгүй байх нь.

Иргэний зориг, Ногоон намын “Монголдоо сайхан амьдаръя” гэх уриа үг хулгайн хэрэгт сэжиглэгдсэн гэнэ. Учир нь, тэдний уриа МАН-ын “Эх орондоо сайхан амьдарцгаая” гэдэгтэй агаар нэг юм.



мөр мөрөөр нь толгой сүүл холбоод сүрхий уриа үг сонгожээ.

Дараа жилийн наадам хол байна даа гэдэг шиг дараагийн УИХ-ын сонгууль ч хол байна.

Ирэх сонгуулиар хөгжлийг арай өөр өнцгөөс харсан, илүү ухаалаг бөгөөд богино уриа үгээр нэр дэвшигчид өрсөлдөөсэй билээ. ■

ЭХ ДЭЛХИЙН МАНЛАЙЛАГЧ

**“НОГООН” ЕРӨНХИЙЛӨГЧ**

Дэлхий дахинаа өнгөрсөн сард байгаль орчны асуудлаар өрнөсөн үйл явдлын гол эзнээр Монгол Улсын Ерөнхийлөгч тодорсон юм. Манай Ерөнхийлөгч олон улсад ногоон өнгөөр гэрэлтсэн од болжээ.

**Э.ЗОРИГТ**

Бразил Улсын Рио де Жанейро хотноо болсон, НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрөөс зарладаг “Эх дэлхийн манлайлагчид” шагналын 2012 оны эзнийг зарласны дараа олон улсын 20 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл “Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нь “Ногоон” Ерөнхийлөгч хэмээн бичиж дэлхий даяар цацсан. Мөн “Эх дэлхийн төлөө хамгийн зөв шийдвэр гаргаж, манлайлж, бусдадаа үлгэрлэсэн танаар бид бахархаж байна” хэмээн НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн захирал ноён А.Штайнер хэлжээ. Товчхондоо дэлхий дахинаа өнгөрсөн сард байгаль орчны асуудлаар өрнөсөн үйл явдлын гол эзнээр манай улсын Ерөнхийлөгч, тодорсон юм. Монгол Улсын Ерөнхийлөгч олон улсад ногоон өнгөөр гэрэлтсэн од болсон гэсэн үг.

Дэлхий нийт Ерөнхийлөгчийг маань үнэлээд байхад бид бахархах ёстой бус уу. “НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн “Эх дэлхийн манлайлагч” шагналын “Бодлогын манлайлагч” шагналыг ОХУ-ын Ерөнхийлөгч асан Нобелийн шагналт М.С.Горбачёв, АНУ-ын дэд Ерөнхийлөгч асан Нобелийн шагналт Аль Гор, Мексик Улсын Ерөнхийлөгч Ф.Калдерон, Малдивын Ерөнхийлөгч асан М.Нашийд, Монакогийн гүн Хунтайж II Альберт нарын нэр хүндтэй удирдагчид хүртэж байсан аж. Тэгвэл энэ нэр хүндтэй шагналд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг дэлхий нийт чухам ямар шалгуураар тэнцүүлсэн юм бол.

**Есдүгээр сарын 1-нд Ерөнхийлөгч юу хийж байв**

Намар цаг ирж, модод нүцгэрч, өвсний үзүүр гандаж

эхэлсэн ч шинэхэн цэцэгс саяхан дэлбээгээ нээв үү гэлтэй хотын гудамж, улаан, ягаан, цагаан, цэнхэр өнгөөр солонгорно. Хүүхэд бүрийн сэтгэл догдолж, дуу шуу хадаан хорвоод хөг ая нэмэх ажээ. Жил бүрийн есдүгээр сарын 1 ийм л яруухан.

Өнгийн тууз зүүж, цагаан цамц өмссөн сурагчид чив чимээгүй. Хэн нэгийг хүлээн амьсгаа даран сууцгаах аж. Уг нь завсарлагааны хонх дуугарах мөчид хүүхдүүд сургууль доргитол бужигналддагсан. Гэтэл 2009 оны хичээлийн жилийн анхны өдрийн хоёрдугаар цагийн завсарлагаан ер бусын намуухан байх аж. Учир нь, энэ өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Нийслэлийн Сүхбаатар дүүргийн III сургуулийн хоёрдугаар цагийн хичээлийг “Дэлхийн дулаарал” сэдвээр заах юм. Чухам энэ л өдрөөс хойш уг хичээл жил бүрийн есдүгээр сарын 1-нд тухайн жилд тулгамдаж буй хамгийн гол асуудлыг шийдвэрлэх үүднээс уламжлал болон хоёрдугаар цагийн хичээл болсон юм.

**Мод тарья**

Нэг мод тарьвал нэгэн насны буян, хоёр мод тарьвал хойд насны буян гэдэг. Харин нэг жилд хоёр сая мод тарьвал, тарихыг уриалж чадсан бол хэдэн насны буян болох бол.

Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар манай улс мод тарих үндэсний өдөртэй болсон. Уг өдрийн хүрээнд монголчууд бид өдгөө жил бүр дунджаар хоёр сая орчим мод тарьдаг болоод байгаа аж. “Хүн бүр 10 мод тарья” уриалга нь дэлхий даяар хэрэгжвэл хүн төрөлхтөн жилд дунджаар 70 тэрбум мод тарьж болох ажээ. Сайхан санаа биш гэж үү. Бүгдээрээ мод тарья. ▶



## ► Эмзэглэлийн эсрэг

Уул нь тал, тал нь там болтлоо сэндийчүүлсэн эх нутгийн байгаль гунигтай дүнсийж, салхи сэвэлзэх төдий шороо босон хуйлрах нь сэтгэл өвдмөөр. Монгол орны хаа сайгүй уул уурхайн балгаар сүйдсэн энэ мэт дүр зураг нүднээ тодхон. Тухайлбал, Төв аймгийн Заамар, Өвөрхангайн Уянга, Бат-Өлзий, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө гээд өврийн сайхан хангай, өргөн сайхан тал нутгийн минь онгон зэрлэг байгалийн дүр зураг өнөөдөр дурсамж болон үлдсэнийг гэрчлэх баримт олон. Дусал ус, дэлбээгээ нээх цэцэггүй болж буй нутгаа харахаар монгол хүний сэтгэл эзгүйрнэ.

Чухам ийм нөхцөлд, тодруулбал Монгол орны газар нутгийн 46 хувийг уул уурхайн лицензтэй талбай эзлээд байсан тэр үед Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж уул уурхайн лиценз олголтыг зогсоох шийдвэр гаргасан нь байгаль орчинд хамгийн ээлтэй шийдвэр болсон. Олон нийтийн дургүйцлийг хүргэн байж гаргасан энэ шийдвэр Монголын газар шороог сүйрүүлэхээс бага ч болов хамгаалсан юм. Энэ мэт хийсэн, санаачилсан ажлууд нь түүнийг “Эх дэлхийн манлайлагч” болгов.

Түүнчлэн утаатай Улаанбаатарыг утаагүй болгох хууль санаачилж батлуулсан, сэргээгдэх эрчим хүчийг дэмжиж, цөлжилтийн эсрэг тэмцсэн гээд дурдаад байвал байгальд ээлтэй олон ажил санаачилж, заримд нь өөрийн биеэр үлгэрлэн, хүрз барин оролцож явсныг хүмүүс мэднэ. Тэрбээр олон улсын тавцанд байгаль орчныг хамгаалах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн зөвлөлийн гишүүн аж. Тухайлбал, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөлийн гишүүн, Давосын эдийн засгийн чуулганы Усны нөөцийн бүлгийн гишүүн юм. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар 2010 онд Монгол Улсын Засгийн газар ээлжит хуралдаанаа Өмнийн говьд хийж, дэлхийн дулаарлын

асуудлаарх илгээлтийг НҮБ-д илгээж байжээ. Мөн түүний санаачилгаар Дэлхийн усны судлалын зөвлөл Монгол Улсыг судалгаандаа хамруулахаар болж, хамтын ажиллагааны эхний алхмууд эхэлсэн байна.

НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрөөс санал болгож, салбар бүрийн лидерүүдээс санал хураасны үндсэн дээр уг шагналын эзнийг тодруулдаг байна. Санал асуулгын үеэр “Ц.Элбэгдорж нь байгаль орчныг хамгаалахад онцгой үүрэг гүйцэтгэж, үр дүнтэй бодлого хэрэгжүүлж, үйл ажиллагаагаараа нотлон харуулж чадсан удирдагч болох нь харагдсан тул уг шагналыг өгсөн” гэжээ.

Монголын эдийн засгийн хөгжил хурдасч байгаа үед “Mongolian Economy” сэтгүүл мэндэлж, анхныхаа дугаарыг “Дэлхийн шинэ хандлага ногоон хөгжил” нэрийн дор гаргаж байсан билээ. Сэтгүүлийнхээ анхны дугаарыг 2011 оны “Монголын эдийн засгийн чуулган”-ы үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид гардуулах мөчид тэрбээр “Эдийн засгийн өндөр өсөлттэй энэ үед энэ талын мэргэжлийн сэтгүүл мэндэлсэнд баярлаж байна. Дээрээс нь танай сэтгүүл ногоон хөгжил, тэр дундаа усны ариг гамтай хэрэглээний талаар маш сайн хөндсөн нь их таалагдлаа. Ногоон хөгжлийн талаар улам их бичээрэй” хэмээн урам хайрласан билээ.

Эдүгээ манай сэтгүүл дэргэдээ “Ногоон эдийн засгийн өсөлт” төрийн бус байгууллага байгуулж, ард иргэдэд энэ талын ойлголтыг сурталчилан таниулах үйлсэд хүчин зүтгэж явна. Мөн төрийн түшээд, бодлого тодорхойлогч нарт ч ногоон хөгжлийн талаар сурталчлах багагүй ажлыг хийжээ. Цаашдаа ч хийх ажил бидэнд их байна. Хамтын хүчээр ногоон хөгжлийг бий болгоно. “Ногоон хөгжлийн төлөө” уриатай манай хамт олон Монгол Улсын Ерөнхийлөгчийг ногоон тодотголтой “Эх дэлхийн манлайлагч” шагнал хүртсэнд баяр хүргэе. ■

НОГООН ХӨГЖИЛ

## Т.ЧУЛУУН: МОНГОЛОО НОГООН СОЁЛ ИРГЭНШЛИЙН ӨЛГИЙ НУТАГ БОЛГОЁ

Судлаач хүний нүдээр сүүлийн 20 жилийг эргээд харахад, Монгол Улс тогтвортой хөгжлийн түвшнээр хамгийн муу замналаар явж байна.

Б.УУГАНБАЯР

**Н**огоон эдийн засаг, ногоон хөгжлийн гал тэргэнд улс орон бүр гар өргөн суух болсон. Манай улсад ч энэ цуваанаас хоцрохгүй, нэгдэх шаардлага тулгараад байна. МУИС-ийн профессор, доктор Т.Чулуун тогтвортой хөгжил, ногоон ирээдүйн төлөө Монголдоо болон олон улсын хэмжээнд сүүлийн 10 гаруй жил ажиллаж буй эрдэмтэн юм. Тэрбээр хүн-байгалийн буюу нийгэм-экологийн тогтолцооны дасан зохицохуй, сэргэн хөгжихүй болон тогтвортой хөгжлийн асуудлыг орон нутаг, улс орон болон бүс нутгийн түвшинд судалдаг эрдэмтэн билээ. Т.Чулуун доктор Монголдоо МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэн, Ногоон хөгжлийн бодлогын хүрээлэнг байгуулан ажиллаж буй. Хилийн чанадад гэвэл, 2014 он хүртэл АНУ-ын Колорадо Их сургуулийн Байгалийн нөөц, экологийн лабораторийн эрдэм шинжилгээний ахлах зочин ажилтан, 2016 он хүртэл АНУ-ын Аризона Их Сургууль болон Өвөр Монголын Их Сургууль дундын (SUCCESS) төвийн зочин профессороор ажиллаж байна.

Ингээд түүнтэй ногоон эдийн засаг, дэлхийн нийтийн тогтвортой хөгжлийн чиг хандлага, манай улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, цаашид тогтвортойгоор хөгжүүлэх ямар боломж байгаа талаар ярилцлаа.

**-Та Бразилийн Рио Де Жанейро хотноо болсон дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн замналыг**

**тодорхойлох “Рио+20” уулзалтад оролцоод ирсэн. Явсан газрын сонинсооо хуваалцана уу?**

“Рио+20” дээд хэмжээний уулзалтын Тогтвортой хөгжлийн төлөөх шинжлэх ухаан, технологи, инновацийн салбар хуралдаанд оролцоод ирлээ. Уулзалтад 140 гаруй улс орны эрдэмтэн судлаач, төрийн өндөр албан тушаалтнууд оролцож, улс орныхоо болон бүс нутгийн дэлхийн тогтвортой хөгжлийн асуудлыг хэлэлцсэн. Ингэхдээ тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах хүрээний ногоон эдийн засаг, тогтвортой хөгжил засаглалыг бэхжүүлэх гэсэн хоёр гол сэдвийг онцолсон.

Миний хувьд өөрийн санаачилсан “Улс орнуудын Тогтвортой хөгжлийн индекс”-ээ танилцууллаа. Улаанбаатар хотынхоо тулгамдаж буй агаарын бохирдол, замын түгжрэл, хот төлөвлөлтийн байдал, агаарын бохирдлыг хэрхэн бууруулах талаар ч түлхүү ярьсан. Үүнийг шийдэхийн тулд баруунд нэвтэрсэн өндөр технологийг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэх боломж, бололцоог нээхийг олон улсын төлөөлөгчид хэлж байсан. Мөн би Монголдоо оюутны ногоон хотхон байгуулж, барууны орчин техник, технологийг нэвтрүүлж, ногоон техник, технологийн төвтэй болох санааг дэвшүүлсэн. Энэхүү төвд бэлтгэгдэн гарч буй оюутан, залуучууд ногоон хөгжлийн ирээдүйг бүтээх болно гэсэн санаа л даа. Хурлын үеэр өөр нэг хөндөгдсөн чухал асуудал бол “Дэлхийн ирээдүй” хөтөлбөрийг албан ёсоор зарлаж

нээлтийг нь хийсэн. Дэлхийн шинжлэх ухааны байгууллагуудаас зарлаж буй энэ хөтөлбөрт байгалийн, нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд, судлаачид бодлого боловсруулагчидтайгаа хамтарч, тогтвортой хөгжлийн шатаа хэрхэн ахиулах талаар арван жилийн хөтөлбөрийг боловсруулж байгаа юм. Хүний амьдралын нэг эрин буюу сүүлийн 60 жилийн хугацаанд бүх зүйл асар хурдан өөрчлөгдөж, хүн төрөлхтний үйлдэл дэлхий тогтолцоонд хүртэл нөлөөлдөг болчихоод байна. Бид дэлхийдээ аюул заналхийлэл үзүүлсээр байна. Наад зах нь цаг уурын өөрчлөлт, түүнд дасан зохицох, хүлэмжийн хийг ялгаруулахыг бууруулах асуудал чухлаар тавигдаж буй. Хүний буруутай үйлдлээс үүдэж байгаль орчны доройтол, цөлжилт, усны, экологийн төрөл зүйлийн хомсдол жил ирэх тусам нэмэгдсээр. Сүүлийн хорин жилийн хугацаанд улс орнууд тогтвортой хөгжлийн чиглэлээр хэр ахиц дэвшил гаргасан, юу дутагдаж буйгаа дүгнэсэн. Дэлхийд тулгамдаж буй байгаль орчны арван асуудлыг тодорхойлоход оролцсондоо талархаж байна.

**-Гаднын орнууд ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийг эн тэргүүнд тавьж буй. Тэгвэл манай улсын тогтвортой хөгжлийн бодлого хаана явна вэ?**

-Судлаач хүний нүдээр сүүлийн 20 жилийг эргээд харахад, Монгол Улс тогтвортой хөгжлийн түвшнээр хамгийн муу замналаар явж байна. Энгийн жишээ татахад, Монгол



► Улсын агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрсэн, цөлжилт ихэссэн. Баян, ядуугийн ялгаа улам нэмэгдэж, ядуурал 40 гаруй хувьд хүрлээ. Энэ нь манай улсын эдийн засаг, байгаль, нийгмийн хөгжил дорой байгааг бэлхнээ илтгэж байна. Эдийн засгийн өсөлт өндөр байгаа ч иргэддээ наалдахгүй хөөстэй, нөгөө талаас байгаль орчны асуудал хурцаар тавигдах болсон. Үүнд юуны урьд уул уурхайн үйлдвэрлэл хурдан хөгжиж буйгаас тоосжилт, утаа ихэсч, усны нөөц багасаж, хоол хүнсний аюулгүй байдал алдагдаж байна.

Мөн уур амьсгалын өөрчлөлт улам хүчтэй явагдаж байна. Усны нөөц хомсдож, хуурайшил ихэслээ. Хүний хэрэгцээг хангах үйлдвэрлэл байгальд хохирол учруулж, хог хаягдал ихээр гаргаж, энэ нь эргээд хүрээлэн буй орчноо доройтуулж байна. Эдгээр зохисгүй байдал нь хүн төрөлхтнийг экологийн сүйрэл рүү ойртуулсаар байна. Иймд эдийн засгийн өсөлтийг байгаль орчны хямралыг бууруулах асуудалтай уялдуулан авч үзэх зайлшгүй шаардлага гарчээ.

Нөгөөтэйгүүр БОАЖЯ, НХХЯ шийдвэр гаргахад нөлөө үзүүлдэг

хүчтэй субъект байж чадахгүй байна. Ийм болохоор л манай улс "Тогтвортой хөгжлийн" өнцгөөс харвал муу дүн авч байна.

**-Монгол Улс хориод жилийн өмнө Тогтвортой хөгжлийн үндэсний стратеги боловсруулж, хөтөлбөр баталсан. Харин өнөөг хүртэл бидний гарт баригдаж, нүдэнд харагдах үр дүн төдийлөн байхгүй байгаагийн шалтгаан таны бодлоор юу вэ?**

-Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр, стратеги байгаа ч тэр бүр үр дүнтэй хэрэгжих боломж нь алга. Систем судлаач хүнийхээ үүднээс аваад үзвэл бид эрчим хүчний хэрэглээ, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, эсвэл иргэдийнхээ ухамсрыг өөрчлөх, тогтвортой хөгжлийн нэгдсэн бодлоготой болох зэргээр тулгамдаж буй асуудлаа тодорхойлон, шийдэж эхлэх шаардлагатай байна. Жишээ нь, нүүрсээ түүхийгээр нь гадагш гаргалгүй аль болох тэргүүний технологийг оруулж ирж, дотооддоо нэмүү өртөг шингээх нь зөв юм.

Мөн бид бололцооныхоо хэрээр сэргээгдэх эрчим хүчийг ашиглах хэрэгтэй. Манай улс хойд хэсэгтээ усан цахилгаан станц, төв хэсгээрээ салхин цахилгаан станц, говьд нарны эрчим хүч ашиглах бүрэн боломжтой. Дээр нь эрчим хүч хэмнэх ногоон технологийг хөгжүүлэх нь эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлын нэг юм. Ингэхлээр аль болох байгалийн нөөцөө хэмнэсэн технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж эхлэх нь чухал байна. Гэтэл бид одоо хүртэл V цахилгаан станц, их чадлын усан цахилгаан станц барьж чадахгүй л дэмий ярьсаар сууна.

Өөр нэг чухал зүйл бол баян, ядуугийн ялгааг багасгах асуудал. Судалгаагаар баян, ядуугийн ялгаа бага орнуудад нийгмийн нөхцөл нь таатай, эрүүл мэнд, гэмт хэрэг, бие биедээ итгэх итгэл, амьдралын чанар хамгийн өндөр байна. Эдгээр улс Тогтвортой хөгжлийн индекст цойлоод гараад ирж байна. Үүнд, Швед, Норвеги, Дани, Япон улсууд дараалан ороод ирсэн байх жишээтэй. Тэгэхлээр авлига, хээл хахууль авч, шударга бусаар баяжиж буй бизнесүүдийг хязгаарлах нь чухал байгаа юм. Энд тэнд үсчиж, олон ►

► зүйлд сатааралгүй тогтвортой хөгжил рүү хөтлөх, голлох зүйлсдээ анхаарах хэрэгтэй байна.

**-Бодлого тодорхойлогчид ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийн талаар ойлгохыг хүсэхгүй байгаагаас шийдвэрүүд нь байгальд ээлтэй бус байна гэж үзэж болох. Тэгэхээр улс төрчдөд энэ талын ойлголт өгөхийн тулд юу анхаарах ёстой вэ?**

-Монгол Улс дэлхийтэй өрсөлдөж гэж бодож байгаа л бол мэдлэггүй улстөрчдийг сургахаасаа илүү гадаад, дотоодод тэргүүлэх салбаруудаар өндөр боловсрол эзэмшсэн, дэлхийд өрсөлдөхүйц чадвартай хүмүүсээ ажиллуулах хэрэгтэй.

**-Ногоон эдийн засгийг энгийнээр хэлбэл?**

-Тогтвортой хөгжлийг маш энгийнээр хэлбэл, ирээдүй хойч үеийнхэнд сайхан амьдрах нөхцөл бүрдүүлж өгөх. Хүн бүхэн л үр, хүүхдээ сайн, сайхан амьдруулахыг хүсдэг. Тэгвэл эдийн засаг, нийгэм, байгаль орчны таатай, аюулгүй байдлыг бүрдүүлэх нь бидний үүрэг. Ногоон эдийн засаг тогтвортой хөгжлийн салбар ухагдахуун юм. Бид эдийн засгаа хөгжүүлэхдээ аль болох байгальд ээлтэй, эдийн засгийн үр ашгийг бий болгож чадвал ногоон хөгжлийн үндэс тавигдана.

**-Ногоон хөгжлийн замнал, туршлагаараа дэлхийд тэргүүлж, үлгэр жишээ болж буй Швед, Швейцарь зэрэг орноос бид юу суралцах ёстой вэ. Манайд аль улсын хөгжлийн хэв загвар түлхүү тохирох бол?**

-Бид ямар нэг байдлаар алсын загвараа тодорхойлон харж байх нь зүйтэй. Тогтвортой хөгжлийн индексээр манлайлж буй улсуудын нэгж хүлэмжийн хий ялгаруулах хэмжээ бага буюу эдийн засаг, эрчим хүчний үр ашиг өндөр технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж буйд ногоон хөгжлийнх нь гол нууц байгаа юм. Жишээ нь, Норвеги нийт цахилгааныхаа 99 хувийг усан цахилгаан станцаас хангаж байхад, Дани салхины эрчим хүч, Герман нарны эрчим хүчийг ашигладагаараа дэлхийд тэргүүлэх байр суурьтай явна. Эдгээр улсад баян, ядуугийн



ялгаа бага байгаа учир иргэдэд бие биедээ итгэх итгэл өндөр, гэмт хэрэг, стресс бухимдал бага, эрүүл мэнд, боловсролын үзүүлэлт сайн гарч буй. Харин энэ асуудал манайд үнэхээр тулгамдаж буй нь бидний нүдэн дээр ил харагдаж байна. Норвеги, Финлянд, Дани, Швейцарь зэрэг орон дэлхийн хойд хэсэгт оршдог, хүн амын нягтаршлын хувьд болон байгаль цаг уурын хувьд ч зарим талаараа Монголтой адил төстэй тул эдгээр орны тогтвортой хөгжлийн жишээг авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой.

**-Тогтвортой хөгжлийг төлөвшүүлэхэд олон нийтийн оролцоо хэр чухал вэ?**

-Дэлхий нийтэд тогтвортой хөгжихөд олон нийтийн идэвх оролцоо хамгаас чухал. Жишээ нь, Япон улсад байгалийн гамшигт цунами болоход иргэд нь хэрхэн тайван хүлээн авч, хамтын хүчээр даван туулж буйг дэлхий нийтээр харсан. Өөр нэг жишээ бол, Европын эдийн засгийн хямрал болоход Герман улсын эдийн засаг их хэмжээний хохирол амсалгүй өнгөрлөө. Энэ мэтчилэн тогтвортой хөгжлийг улс орныхоо тэргүүний луужин болгосон орнуудын иргэдийн хооронд нягтрал сайн, хамтач дүр зураг харагдаж буй. Үүн дээр төрийн зүгээс зөв зүйтэй ногоон эдийн засгаа дэмжсэн бодлого явуулахын зэрэгцээ иргэдийн өөрсдийнх нь идэвх оролцоо, санал санаачлага, хяналт үнэхээр чухал хөшүүрэг болдог.

**-Өнгөрсөн дөрөвдүгээр сард Лондон хотноо “Дарамтад буй дэлхий” сэдэвт эрдэмтэн, судлаачдын чуулга уулзалтаар дэлхийн ирээдүйн тогтвортой хөгжлийн арван жилийн хөтөлбөрийг баталжээ. Дэлгэрүүлж ярина уу?**

-Эрдэмтдийн үзэж буйгаар хүн төрөлхтөн геологийн шинэ эрин үе болох Антропоцентд шилжиж оржээ. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш эдийн засаг, технологийн хөгжил, хүн ам, байгаль орчны өөрчлөлт улам бүр хурдассаар байна.

Сүүлийн 60 жилийн хугацаанд хүн өөрөө эх дэлхийн өөрчлөлтийн гол хүчин зүйл болсон. Уур амьсгалын болон дэлхийн бодисийн циклийн өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн мөхөл нь дэлхийн тогтолцооны аюулгүйн бүсээс хэдийнэ давсан байна. Тухайлбал, агаар мандал дахь хүлэмжийн хийн хэмжээ нь сүүлийн 800 мянган жилийн байгалийн хэлбэлзлээс давсан нь дэлхийн дулаарлыг үүсгэх хүчин зүйл болж байна.

Иймээс дэлхий тогтолцооныхоо тогтвортой байдлыг хангах яаралтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор энэ хөтөлбөрийг санаачилсан. Бид ирэх онд тус хөтөлбөрийн механизмын бүх асуудлаа шийдээд 2014 оноос үйл ажиллагаагаа эхэлнэ. Юун түрүүнд бүс нутаг тус бүрээр тогтвортой хөгжлийн тулгамдаж буй асуудлыг ►

дүгнэж, хэрэгжүүлэх арга замаа тодорхойлно. Миний хувьд Ази, Номхон далайн олон улсын шинжлэх ухааны зөвлөлийн хүрээнд идэвхжүүлэх үүрэг хүлээсэн. Монголдоо энэхүү хөтөлбөрийг үр дүнд хүргэхийг зорьж, хичээн ажиллах болно.

**-Монголчууд хөгжлийн чиглэлээр муу дүн авчээ. Харин ирэх 20 жилийг Та хэрхэн төсөөлж байна вэ?**

-Өнгөрсөн 20 жилд юу алдсанаа ярьсан. Энэ нь тийм ч урт хугацаа биш. Монгол Улс ирэх 20 жилд ногоон соёл иргэншил гэсэн үзэл санааг дэвшүүлээд хөгжүүлэх бололцоо бий. Үүнд ногоон эдийн засаг, уламжлалт соёл иргэншлээ сэргээх, ногоон нийгэм, хүмүүсийн зохистой хэрэглээ гээд олон зүйлийг ойлгож эхлэх хэрэгтэй. Хүн төрөлхтний хэрэглээ ямар нэг байдлаар мухардалд орох гээд байгааг эрдэмтэд судалж байна.

Цэнхэр гаригийн нийт хүн амд бидний амьдарч буй дэлхий багадаад, нэмээд хагас дэлхий шаардлагатай болоод байгаа. Хүн амын хэрэглээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж буй. Судалгаагаар хэрэв дэлхий дээр амьдарч буй бүх хүн америк хүн шиг хэрэглээтэй болоод ирвэл зургаа эсвэл долоон дэлхий хэрэг болохоор байгаа юм. Энэ нь дэлхий ачааллаа даахаа больж буйн жишээ.

Тэгэхээр одоо цоо шинэ, ногоон соёл иргэншлийг бүтээх шаардлага өөрийн эрхгүй гарч ирлээ гэсэн үг. Бид XIII зуунд Чингис хаанаараа овоглон дэлхийн талыг эзэлж, урлаг соёлоо түгээж байсан бол ирээдүйн 20 жилд яагаад ногоон соёл иргэншлийг түгээж, загвар ногоон улс болж болохгүй гэж.

**-Их бүтээн байгуулалт, хүн амын өсөлт, уул уурхайг дагаж усны хэрэгцээ өдөр ирэх тусам нэмэгдсээр байгаа ч нөөц нь хомсдож байна. Усны зөв менежментийг хэрэгжүүлж, энэ асуудлыг шийдэх гарц нь юу байна вэ?**

-Улаанбаатарчуудын ундны ус хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Юун түрүүнд дагавар хотуудаа яаралтай хөгжүүлэх нь чухал. Жишээ нь, Багануурт гэхэд оюутны ногоон хотхон байгуулж, шинжлэх ухааны академийг нүүлгэвэл нийслэлчүүдийн

усны ачааллыг багасах боломж гарч ирнэ гэсэн үг. Дээр нь нийслэл хотоо шинэ газар шилжүүлэн нүүлгэж ногоон соёл иргэншлийн өлгий нутагтай болох боломж нь бүрдэнэ. Миний бие Өвөр Монгол, Солонгос, Японы нийслэл хотын зохион байгуулалт, дэд бүтэц, усны асуудлаа хэрхэн шийдсэнийг харж явлаа. Хамгийн сүүлд Малайз нийслэлээ нүүлгэснийг очиж үзсэн. Үүнд хөрөнгө мөнгө, цаг хугацаа багагүй зарцуулах ч одоогийн нийслэлийн нөхцөл байдлыг харахад хамгийн зөв гарц ч байж болох юм.

Түүнчлэн энэ жилээс Онги, Байдрагийн гол зэрэг усны ай савыг хамгаалах төслийг Колорадагийн их сургуулийн эрдэмтэн Деннис Ожима манай МУИС-ийн Тогтвортой хөгжлийн хүрээлэнтэй хамтарч хэрэгжүүлэх гэж байна.

**-Улс орнуудын Тогтвортой индексээр манай улс ямар түвшинд байна вэ?**

-Хүний хөгжлийн индексийг боловсруулахаар анх ажиллаж байхдаа би Тогтвортой хөгжлийн индексийг 2012 онд Лондонгийн хуралд зориулан гаргасан. Ингэхдээ тухайн улсын нэг хүнд ногдох ДНБ, хүлэмжийн хийн ялгаруулалт болон баян, ядуугийн ялгаа бага байх хэмжээгээр нь тооцоолсон. Энэхүү 147 орныг үзүүлэлтээр жагсаахад Швед, Герман, Япон, Норвеги улс тэргүүлэх эгнээнд ороод ирсэн байх жишээтэй. Бүсээр нь авч үзвэл, Африкын орнууд сүүлж мушгиж, Европ болон Скандиновын орнууд тэргүүлсэн. Монгол Улсын хувьд дундаас доош түвшинд л явж байна даа.

**-Олон улсын жишигт байгаль орчин, хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд эдийн засгийн ямар хөшүүрэг хэрэглэдэг вэ?**

-Дэлхий нийтэд байгаль орчноо хамгаалахын тулд эдийн засгийн хөшүүрэг, урамшуулал, уралдаан, компанит ажил зэрэг олон арга хэрэглэдэг. Англи улс байгаль орчноо хамгаалахаар "Ногоон хөрөнгө оруулалтын банк" байгуулж ногоон дэд бүтэц, ногоон бодлогын хэрэгжилт, ногоон эдийн засгийг дэмжиж буй хувийн хэвшлүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байх жишээтэй. Харин БНХАУ-д Засгийн газраас ногоон зээл,

ногоон кредит бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Уг бодлого хэрэгжсэнээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж түүхий нүүрсээр ажилладаг цахилгаан станц, ган, хөнгөн цагаан, цементийн үйлдвэр, хүнд аж үйлдвэрт байгаль орчны шалгалт хийж, санхүүжилт болон бусад үйл ажиллагаандаа хөрөнгө оруулалт хийдэг аж. Австрали улсад "Ногоон эрчим хүч, усыг арвилан хэмнэх хөтөлбөр"-ийн хүрээнд байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг татвараас чөлөөлдөг. Мөн сэргээгдэх эрчим хүч хэрэглэсэн айл өрхийг 10.000 ам.доллар хүртэлх зээлийн хүүгээс чөлөөлөх болжээ.

Энэ мэтчилэн аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд хандсан ногоон бодлогыг эдийн засгийн хөшүүрэг болгон ашиглах нь тун зүйтэй. Манайд энэ чиглэлийн бодлого үнэхээр дутагдалтай байна. Байгальд ээлтэй технологи ашиглан, үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжээ дэмжин "Ногоон сан"-тай болох, ногоон зээл олгох зэрэг боломж бий гэдгийг өнгөрсөн Эдийн засгийн форумын үеэр ярьж байсан.

**-Иргэд, олон нийт, төрийн эрх баригчдад ногоон сэтгэхүй, ногоон хандлагыг бий болгох, уриалах нь чухал гэдгийг олон хүн сануулдаг. Бид ингэхийн тулд нэн тэргүүнд юунаас эхлэх хэрэгтэй вэ?**

-Том бүтээн байгуулалтаа хэлбэл хамгийн түрүүд шинжлэх ухааны ногоон хотхон байгуулахаас ажлаа эхлэх нь зүйтэй. Учир нь, энд байгальд ээлтэй бүхий л ногоон технологийг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн, ногоон хөгжлийг дэмжих боломж бүрдэнэ. Төр, засгийн зүгээс энэ чиглэлд түлхүү анхаарах хэрэгтэй.

Нөгөө талаас дээр хэлсэн ногоон соёл иргэншлийн өлгий нутаг болохын төлөө улстөрчид тархиа гашилган, бодлогоо чиглүүлж, иргэний нийгмийн байгууллагынхан ч дуу хоолойгоо хүчтэй гаргаж, оролцох шаардлагатай.

Харин иргэн таны хувьд үрэлгэн хэрэглээгээ багасгаж, дулаан цахилгаанаа хэмнэн, аль болох байгальд ээлтэй амьдралын хэв маягийг өөртөө бий болгохыг уриалж байна. ■

НАРНЫ ЭНЕРГИ

## ЦАХИРМАА ЦЭЦГИЙН ДИВААЖИН

Дэлхий нийт ногоон өнгөнд “хайр зарлах” болжээ. Ногоон бол XXI зууны бэлгэ тэмдэг. Гэхдээ энэ нь дэлхийг бүрхэх мод, өвс ногоо, ургамал цэцэгсийг хэлээгүй. Харин “ногоон” сэтгэлгээг илэрхийлж буй.

### Б.ҮҮРИЙНТУЯА

Цэнхэр, саарал, шар, ногоон. Энэ бол эх дэлхийг тодорхойлох өнгө. Сансар огторгуйгаас цэнхэртэх манай гаригт саарал усны түвшин ихэсч, шаргал элс газар аван цөлжилтийн аюул дагуулах болсон. Энэ үед дэлхий нийт ногоон өнгөнд “хайр зарлах” болжээ. Ногоон бол XXI зууны бэлгэ тэмдэг. Гэхдээ энэ нь дэлхийг бүрхэх мод, өвс ногоо, ургамал цэцэгсийг хэлээгүй. Харин “ногоон” сэтгэлгээг илэрхийлж буй.

Эрт үед Бурхан бүгдийг бүтээдэг хэмээн ярьдаг байж. Байгаль эхийг хүртэл түүний гараар бүтсэн гэж итгэдэг байлаа. Харин дэвшилтэд технологийн эрин үе энэ зуунд Бурханы бүтээлийг хүмүүн бид бүтээх болжээ. Үүний нэг жишээ бол Сингапурын “Далайн эргийн гэрэлт хотхон” гэгдэх Gardens by the Bay. Сингапур улсын Марина эргийг чимэх тус цэцэрлэгт хүрээлэн нийт 101 га газар үргэлжлэх бөгөөд улсынхаа алдрыг өргөх гайхамшгуудын нэгд зүй ёсоор ордог. Хүн төрөлхтөний гараар бүтсэн эл “хотхон”-ы төслийг Сингапурын Засгийн газар 2005 онд санаачлан мөн оны наймдугаар сард Үндэсний Их Чуулганы үеэр олон нийтэд зарлаж байжээ.

Улсынхаа хамгийн том соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн болох Gardens by the Bay нийт гурван цэцэрлэгт хүрээлэнгээс бүрдэх бөгөөд хүрээлэнгийн байгууламж тус бүр халуун орны ургамлын онцлог шинжийг агуулсан байна. Ингэхдээ Сингапурын бэлгэ тэмдэг болох Цахирмаа цэцгийн бүтцээс санаа авч төслийн мастер төлөвлөгөөг боловсруулжээ. Тус улсын Засгийн газар уг төслийг хэрэгжүүлэх олон улсын тендерийг 2006 онд зарлан, 170 гаруй гадаад, дотоодын байгууллагын 70 гаруй төслөөс сонгон шалгаруулалт хийхэд ийнхүү “Grant Associates”, “Gustafon Porter” гэсэн хоёр байгууллага хэрэгжүүлэгч компаниар тодорсон юм.



### Байгальд ээлтэй цэцэрлэгт хүрээлэн

Халуун орны содон бүхнийг агуулсан тус цэцэрлэгт хүрээлэн Bay East, Bay Central болон Bay South гэсэн гурван хэсгээс бүрддэг. Гэрэлт хүрээлэнгийн зүүн жигүүрт байрлах Bay East-ийг 2010 онд Сингапурт анх удаагаа ▶



“Gardens by the Bay” цэцэрлэгт хүрээлэн

► зохион байгуулсан Залуучуудын Олимпын их наадамд зориулан байгуулсан. 2011 оны арваннэгдүгээр сараас тус хүрээлэн олон нийтийн мэлмийг баясгах болжээ. Халуун оронд ургадаг нэгэн модны навчийг загвар болгон барьсан эл хэсэг ус дамжуулах таван гарцтай бөгөөд далайн эрэгтэй шууд холбоотой учир зочид, гийчдэд сэрүүн салхи,

цэнгэг усаар наадах боломжийг олгодог юм байна.

“Gardens by the Bay” цэцэрлэгт хүрээлэнгийн төв хэсэг Bay Central-ийг бүтээн босгох ажил өнөөдөр харахан дуусаагүй байна. Bay South буюу өмнө эрэгт орших цэцэрлэгт хүрээлэн өнгөрсөн сарын 29-нд нээлтээ хийсэн юм. Олон мянган зочны нүдийг хужирлах Bay ►

► South нь хүрээлэн хамгийн том талбайг эзлэх бөгөөд нийтдээ 55 га газарт “Бурханы бүтээл”-ийг дэвшилтэт технологийн тусламжтайгаар цэцэгжүүлжээ. Халуун орны байгалийн илэрхийлэл болсон эл газар тэр чигтээ “ногоон” аж.

Үүлэн шугуй, Цэцэгсийн ордон зэрэг хүлэмжийг мөн л үндэсний бэлгэ тэмдэг Цахирмаа цэцгийн хэлбэрээр урлажээ. Хүрээлэнгийн гол бүтээн байгуулалт болох тэдгээр хүлэмж хөл бөмбөгийн талбайтай тэнцэх газрыг хамрах агаад тив бүрийн нийтдээ 220 мянган ургамлын их гэр болж байгаа юм. Хүлэмжээс гарсан ургамлын хаягдлыг нягтаршуулж, ууршуулах замаар эрчим хүч бий болгон улмаар био хүлэмж доторх температурыг хэвийн байлгах аж.

Бас нэгэн өвөрмөц ногоон шийдэл. Цэцэрлэгт хүрээлэнгийн гоёл болсон аварга хиймэл модод Сингапур улсын ногоон хөгжлийн түвшинг харуулна гэхэд хилсдэхгүй болов уу. Тэнгэр баганадах тэдгээр мод 50 метрийн өндөрт сүндэрлэх бөгөөд нарны эрчим хүч хуримтлуулах, борооны ус тосох зэрэг үүргийг хүлээжээ. Хүний гараар бүтсэн тус механик шугуйд нийт 18 ийм төрлийн мод суулгасан байна. Үүний 11 модонд нарны энергийг эрчим хүч болгон хувиргах системийг байршуулсан нь хүрээлэнгийн бусад хэсгийг цахилгаан болон хэрэглээний усаар хангах боломжийг бүрдүүлжээ. Түүнчлэн модны их биед халуун оронд түгээмэл ургадаг цэцэгс шигтгэсэн нь нүдийг баясаж, сэтгэлийг сэргээх уран арга болсон байна.

## Эко элч


Сингапурын үндэсний бахархал болж чадсан тус цэцэрлэгт хүрээлэнг эко аялал жуучлалын эхлэл болно хэмээн төслийг хэрэгжүүлэгч байгууллагууд дуу нэгтэй хэллээ. Тус улсын Ерөнхий сайд Ли Куан Еив “Манай улсын гайхамшгийн нэг болсон эл хүрээлэн дэлхий дээрх диваажин болно. Энэ нь эх орноо эко элч болгох манай Засгийн газрын зорилгын нэг хэсэг” хэмээн ярьжээ. Ургамлын ертөнц болсон уг цэцэрлэгт хүрээлэн нь Сингапур улсын Засгийн газрын хувьд улсынхаа нийслэлийг “Хүрээлэн дундах хот”-оор өргөмжлөх стратегийн өчүүхэн биелэл гэнэ.

Бүтээн байгуулалтын бүхий л хэсэгт байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашигласан нь байгаль эхийн амар амгаланг ихэд бодолцсоны илрэл аж.

Эко элч далавчаа дэлгэх тэр агшин дэлхий нийтийн “ногоон” сэтгэлгээг улам бадраасан нь тодорхой. ■



Gardens of the Bay цэцэрлэгт хүрээлэнгийн “Усан гайхамшиг” цогцолборт байрлах нарны эрчим хүч хуримтлуулах, борооны ус тосох зориулалттай хиймэл мод



“Bay South” цэцэрлэгт хүрээлэнгийн “Үүлэн шугуй” хүлэмж. Био хүлэмжийн температурыг хэвийн байлгах зорилгоор ургуулсан аварга мод



Bay South цэцэрлэгт хүрээлэнгийн “Цэцэгсийн ордон” хүлэмж. Дэлхий дээр ургадаг нийт 220 мянган төрлийн цэцэгсийн “их гэр”

БАНК

## Л.БОЛОРМАА: АЖИЛТАЙ, БОЛОВСРОЛТОЙ, АЗ ЖАРГАЛТАЙ НИЙГЭМ БҮТЭЭХ НЬ ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮҮРЭГ

Хөгжлийн банк бол хөгжлийн тасалбар. Тиймээс тасалбараа урж, үрчийлгэж болохгүй. Хүчингүй болох эрсдэл их.

### Б.ТОГТОХ

Монгол Улсын Хөгжлийн банкийг удирдан залах, өнөөгийн өндөрлөгт хүргэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг олох амаргүй шалгуурыг туулж яваа нэгэн бол Лувсандоржийн Болормаа. Банк, санхүүгийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж буй тэрбээр өмнө нь “Deutsche Bank”-ны Хойд Америк хариуцсан Банк санхүү, брокер диллерийн салбарын дэд захирлаар ажиллаж байсан. Түүнийг Хөгжлийн банкны тэргүүн дэд захирлын албыг хүлээж авах үед эмэгтэй хүн энэ том шинэ байгууллагыг удирдаж чадахгүй гэх үгийн ирээр мохоосон ч Монгол Улс өнөөдөр дэлхийн хэмжээний итгэлцлийг олсон Хөгжлийн банктай боллоо.

Олон улсын санхүүгийн зах зээлд Монгол Улсын Хөгжлийн банк ханаа дугуйлж, өрхөө татаад нэгэн он тооллыг үдэв. Хүсэл эрмэлзлэл дүүрэн, шижигнэсэн, бүтээлч, оюунлаг 40 гаруй залуусаар Л.Болормаа захирал багаа бүрдүүлсэн байна. Эмэгтэй хүний хатан ухаан, мэдлэг чадвар, туршлага, хөдөлмөрийн шим, сэтгэл Хөгжлийн банкны хөгжлийн төлөө ажиллах үүрэг зорилгыг тодорхойлж өгчээ.



ФОТОГ Э.ЗОРИГТ

Нэг жилийн өмнө ердөө л зургаахан хүнтэй, засвартай байранд үүдээ нээж байсан Хөгжлийн банк өдгөө том айл болж. Ингээд тус банкны Тэргүүн дэд захирал Л.Болормаатай ярилцлаа.

**-Монгол Улс Хөгжлийн банктай болоод нэг жилийг үдлээ. Ямар өөрчлөлт гарсан бэ?**

-Монгол Улсад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг Хөгжлийн банк босголоо. Энэхүү хөрөнгөөр ▶

► улс орны хөгжлийн шинж чанартай томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хөгжлийн хөдөлгүүр болгон ажиллах нь бидний зорилго. Өнгөрсөн хугацаанд таван жилийн хугацаатай, 5.75 хувийн хүүтэй бондоор хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүллээ. Ирээдүйд манай улсын макро эдийн засгийн болон улсын төсвийн бодлого нь зөв оновчтой байвал дараа дараагийн хөрөнгө босгох ажил илүү хялбар байх болно. Өөрөөр хэлбэл, төсөв, мөнгөний бодлого эрүүл байвал 2013 оноос 10, 15, 20 жилийн урт хугацаатай бонд босгож эдийн засгийн хөгжлөө дэмжих боломж бидэнд нээлттэй.

Олон улсын санхүүгийн эгзэгтэй үед Хөгжлийн банк хөрөнгийн эх үүсвэрээ амжилттай бүрдүүлснээр эдийн засагт нэн тэргүүнд ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлэх боломжийг нээж өгсөн. Нийтдээ 415.6 тэрбум төгрөгийн өртөгтэй 662 км зам барих санхүүжилтийг шийдвэрлэлээ.

Мөн ирэх жилээс барилгын ажил нь эхлэх 3300 орчим км замын зураг төслийг манай банкны санхүүжилтээр боловсруулахаар боллоо. 100.000 айлын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд ОССК-иас хариуцан барих “Буянт-Ухаа 2000 айлын орон сууцны хороолол” төслийн эхний гурван барилгын санхүүжилтийн асуудал шийдэгдсэн. Бага, дунд орлоготой иргэдийг зургаан хувийн хүүтэй орон сууцны зээлд хамруулах зорилгоор бид эхний 50 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Төрийн банкинд шийдвэрлэж өгсөн. Хөдөө, орон нутагт шинээр ажлын байр бий болгох үүднээс Жижиг, дунд үйлдвэрийн санд 50 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор ажиллаж байна.

Цаашид зам, төмөр зам, Сайншандын үйлдвэрийн төслүүд, зураг төсөл, тендерийн шийдвэрүүд болон зохих гэрээ хэлэлцээр нь бэлэн болохын хэрээр Хөгжлийн банк санхүүжилтийн асуудлыг нь цаг алдахгүй шийдвэрлэхийг зорьж байна.

**-Танай банкны ажлын үр дүнг улсын хөгжлөөр хэмжиж болох уу?**

-Хөгжлийн банкны эцсийн зорилго

нь ажлын тогтвортой байр бий болгох. Иргэд нь ажлын байртай, тогтсон орлоготой, орлого нь баталгаатай улс орон хөгждөг. Байнгын татаас, дэмжлэг тарааснаар улс хөгжихгүй. Харин ч амжилттай яваа эдийн засгийн өсөлтөө татаж унагах эрсдэлтэй. Мөн иргэдийн боловсрол, санхүүгийн мэдлэг гүнзгий байж өөрийгөө жолоодож, өрхийн амьдралаа авч явна. Ажилтай, боловсролтой, аз жаргалтай нийгэм бүтээх нь Хөгжлийн банкны үүрэг.

Тиймээс бусдаас хараат бус

**Монгол Улс маань хөгжих, сайхан ирээдүй ойртож байна. “Азийн бар” улсуудтай эн зэрэгцэн хөгжих итгэл монгол хүн бүрт бий. Надад ч ийм итгэл байна. Бидний тэмүүлж, тэнд л очиж ажиллах юмсан гэж хүсэн мөрөөдөх тэр мөрөөдөл чинь Монголд хэрэгжих том бололцоо бүрдэж байна. Тиймээс нэгдүгээрт, монголчууд бид өөрт байгаа баялгаа үнэлж сурах хэрэгтэй.**

төрөлжсөн эдийн засгийг бий болгох, стратегийн ач холбогдолтой салбаруудаа түлхүү дэмжиж, улмаар ажлын байр бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Нэг үгээр хэлбэл, иргэд нь ажилтай, орлоготой тэр хэмжээгээрээ хэр аз жаргалтай амьдарч байгаагаас л тухайн улсын хөгжил тодорхой харагдана.

**-Нэг жилийн хугацаанд гадаад хамтын ажиллагаагаа хэр өргөжүүлсэн бэ?**

-Хөгжлийн банк нь Монгол Улсын томоохон төслүүдийг хэрэгжүүлэгч гэдэг үүднээс гадаадын хөрөнгө оруулагч, банк санхүүгийн болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай харилцаагаа хөгжүүлэх чухал шаардлагатай. Өнгөрсөн онд хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг дэлхийн тэргүүлэх байгууллага, банк болон Хөгжлийн сангуудтай байгуулсан. Жишээлбэл, Японы Сумитомо Мицуи банкттай, Хятадын Хөгжлийн банк, АНУ-ын болон Хятадын Экспорт Импортын банкуудтай хамтарч ажиллах гэж байна. Гарын үсэг болгоны ард бодсон төлөвлөгөө, баримт болгонд зорилт байдаг. Тиймээс Японы банкттай хамтарч, өндөр технологийг дотооддоо нийлүүлэх, Сайншандад барих аж үйлдвэрийн цогцолборт өндөр технологийг нэвтрүүлэх нь бидний үйл ажиллагааны үр дүн болох юм.

**-Хөгжлийн банкны хараат бус байдал алдагдах үе байдаг уу?**

-Бидний үндсэн зарчим хараат бус байдал. Хөгжлийн банкны үйл ажиллагааны чиглэл нь өөрөө хараат бус байж эдийн засагт үзүүлэх дэм нөлөө нь илүү үр дүнтэй байх юм. Санхүүгийн байгууллагын хувьд өөрийн эрсдэлээ байнга тооцож, үйл ажиллагаагаа явуулж байж банк тогтвортой хөгжиж чадна. Хөгжлийн банк бие даан төслүүдийг сонгож, үр ашигтай төслүүдэд хөрөнгө оруулснаар банкны санхүүгийн чадавхийг сайжруулж, улмаар манай улсын эдийн засаг төрөлжиж, тогтвортой хөгжилд хүрнэ. Тиймээс манай банкны хараат бус байдлыг зөвхөн хуульд тусгахаас гадна Засгийн газар, Сангийн яамтай жил болгон гэрээ хэлэлцээр хийж биеэ даасан хараат байдлыг хууль зүйн хүрээнд анхаарч ажиллах хэрэгтэй. Хөгжлийн банк бол хөгжлийн тасалбар. Тиймээс тасалбараа урж, үрчийлгэж болохгүй. Хүчингүй болох эрсдэл их.

**-Та санхүүгийн салбарын компанийн засаглалын талаар ямар бодолтой явдаг вэ?**

-Хөгжлийн банкныг олон жил ярьж хэлэлцсэний үр дүнд байгуулсан. Тиймээс энэ байгууллагыг зохистой сайн засаглалтай, өөрийн гэсэн ►



чиглэлтэй буюу нэг шугамаар явах нь чухал байна. Хөгжлийн банктай холбоотой тогтоолууд удах, байн байн өөрчлөгдөх, хууль нь тодорхой бус зэргээс хамааран тогтвортой үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирдаг.

Цаашилбал, банк нь санхүүжүүлэх төслүүдээ өөрөө сонгох ёстой гэсэн гол зарчим одоогоор хэрэгжиж эхлээгүй байна. Гэтэл бусад орны Хөгжлийн банкуудад стратегийн салбаруудыг нь Засгийн газар нь тодорхойлж өгсөн байдаг. Харин Хөгжлийн банк өөрөө хөрөнгө оруулалт, санхүүжилтээ биеэ даан шийдвэрлэдэг байснаараа эдийн засгийн гол хөдөлгүүр болж чадсан.

### Ирээдүйтэй салбараа эртнээс бэлтгэе

**-Монгол Улс тогтвортой хөгжихийн тулд хамгийн түрүүнд аль салбараа түлхүү хөгжүүлэх шаардлагатай вэ?**

-Юун тэргүүнд манайх эдийн засгаа төрөлжүүлэе. Эдийн засгийн онол үзэж байсан оюутан, эрдэмтэн, судлаачид хэлдэг шүү дээ. Тухайн орны бусад улсаас давуу гарах боломжтой салбараа хөгжүүлбэл үр ашигтай. Нэг үгээр хэлбэл, Монгол Улс өрсөлдөх чадвараа олон улсад нээнэ гэсэн үг. Эдийн засгийн бодлогоороо ирээдүйтэй салбараа эртнээс бэлдэж, олон улсын зах зээлд үнэлэгдэж, амжилттай өрсөлдөх ёстой. Монголчууд өөрийн гэсэн брэндтэй болох шаардлагатай байна. Тэгж байж хэтийн хөгжлөө тогтвортой хангана.

**-Тэгвэл Монгол брэнд хэзээ моодонд орох бол?**

-Эдийн засгаа төрөлжүүлэхийн тулд үүндээ зориулж брэндийн бодлого явуулах ёстой. Брэнд гэдэг ганц хоёрхон жилийн хугацаанд тогтдог зүйл биш. Брэнд нь тав, арван жилийн дараа зах зээлд танигдаж, хэрэглэгчээ олдог. Үнэхээр тухайн улс руу тэмүүлж, тэнд сурахыг мөрөөдөж, тухайн улсын бүтээгдэхүүнийг худалдан авахын төлөө сая сая хүмүүсийн санаа бодол нэгдэж байвал тэр брэнд. »

► амьдрах чадвартай байлгахын төлөө зорьж байна. Аливаа орны Хөгжлийн банк ямар нэгэн эрсдэлд орсон тохиолдолд Засгийн газрын түвшинд авч үздэг. Иймээс Хөгжлийн банкийг зөв зүйтэй удирдах нь хамгийн чухал. Хөгжлийн банкаа Сангийн яам, Монголбанк, Засгийн газар нь зөв бодлогоор дэмждэг байх хэрэгтэй. Түүнээс мөр мөрөө хөөгөөд уялдаа холбоогүй, эсрэг тэсрэг бодлого хэрэгжүүлбэл эдийн засаг хүнд байдалд орно. Хөгжил ч биднээс холдоно гэсэн үг.

Герман, Солонгос, Хятадын Хөгжлийн банк бүгд ийм нэгдсэн дэмжлэгээр улсаа хөгжүүлж чадсан түүхтэй. Үүний нууц нь засаглал. Манай банк сайн засаглалтай болохын тулд улс орны хэмжээнд бодож, тооцоолсон санхүүгийн алсын хараа үгүйлэгдэж байна.

Хүрэх газраа зөв тодорхойлж. Улс орон болгон энэхүү бодлогоо өөр өөрөөр зохицуулдаг. Манайд эдийн засгийн бодлогыг ядаж дунд хугацаанд боловсруулаад түүндээ байн байн өөрчлөлт оруулахгүй нэг

► Уг нь Монгол Улс өөрөө брэнд юм. Монгол гэж хэлэхэд л нүүдэлчин соёл, унаган байгаль, хөх тэнгэр, цэнгэг агаарынх нь тухай боддог. Мөн манай орны чацаргана, сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос ноолуур гэх мэт органик бүтээгдэхүүн байна. Монгол гэсэн онцлогтоо таарсан брэнд бий болгоё. Жишээ нь, Тайланд, Индонези аялал жуулчлалын салбараараа дэлхийд үнэлэгддэг. Чили Улс дарсаа дэлхийн брэнд болгож чадсан. Гэтэл эдгээр оронд уул уурхай бас л эрчимтэй хөгжиж байгаа. Тиймээс манайх яг тэдэнтэй адилхан Монголын брэнд юу байх билээ гэдэгт анхаарлаа хандуулах цаг нь болсон.

**-Бидэнд брэнд болгочих хоёр төрлийн бүтээгдэхүүн байна. Ноос ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн. Хаанаас нь эхлэх вэ?**

-Манай брэнд болж чадахуйц бүтээгдэхүүн бол ноос ноолуур. Харамсалтай нь өнгөрсөн хугацаанд ноолуурын хувьд төрөөс зохистой бодлого явуулсангүй. Засгийн газраас ноос ноолууртаа хандсан зорилтот бодлого явуулья. Бодлогын хүрээнд ноолуураа угаадаг, боловсруулдаг том үйлдвэр бий болгох ёстой. Гэхдээ боловсруулах үйлдвэр том байж үр ашигтай ажиллана. Жижигхэн үйлдвэр нэгдүгээрт, цэвэр технологи хэрэглэж чадахгүй. Хоёрдугаарт, гарч байгаа бүтээгдэхүүн нь хэрэглэгчдэд үнэтэй хүрнэ. Боловсруулах том үйлдвэрүүдтэй болсон тохиолдолд ноолуураа түүхийгээр гаргахгүй шүү дээ. Уг нь, манайд Говь гурван сайхан гэсэн ноолуурын брэнд байсан. Тодорхой бодлогогүйн улмаас энэхүү брэндээ хятадуудад алдсан.

Урд хөршийн ноолуур өнөөдөр Монголын ноолуураас илүү болчихсон байна. Манайд онцлох зүйл маш их. Цэвэр агаар, жилийн дөрвөн улиралд дасан зохицсон, онгон байгальд бэлчээрлэж буй хонь, ямааны ноос ноолуур гээд. Италийн "Лора пиано" компани ноолуураа манайхаас авдаг. Гэтэл тус компани ноолуурын бүхэл бүтэн

брэнд бий болгож, түүгээрээ ном хүртэл хийчихсэн байна. Швейцарь Улс манай бүх үйлчилгээ дэлхийд хамгийн дээд чанарынх, Япон манай бүх бүтээгдэхүүн чанартай гэсэн брэнд бий болгосон. Үүнтэй адилхан бид өөрсдийн брэнд гаргах, сэтгэх, тэмүүлэх хэрэгтэй. Түүний төлөө илүү бүтээлчээр хөдөлмөрлөх шаардлагатай.

### **Мэдлэгийг чинь үнэлж, чамайг хүндэлнэ гэдэг аз завшаан**

**-Улстөржилтийг та хэрхэн хүлээн авдаг вэ. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд улс төр нөлөөлж байна уу?**

-Аливаа хөгжсөн улс орныг харахад улстөржих асуудал маш бага байдаг. Сингапур, Швейцарь үүний тод жишээ. Намууд нь хэдий наана цаана болсон ч бодлогоо хэрэгжүүлэх түвшин буюу тухайн салбарын яамандаа ирээд улс төр нь тэр чигээрээ байхгүй болдог. Гэтэл манайд намын томилгоо хөгжлийн саармаг байдлыг бий болгож байна. Ялсан нам нь эдийн засгийн бодлого барих нь зөв ч бодлого хэрэгжүүлэхдээ мэргэжлийн хүмүүсийг томилох учиртай. Мэргэжлийн хүнээс нь үр дүнг нэхэж, ажлын шаардлага тавих хэрэгтэй. Түүнээс улс төрийн томилгоогоор асуудлыг шийдэж боломгүй.

Ер нь монголчууд бага улс төржөөсэй. Манайхан мэргэжлээ дээшлүүлж, улам гүнзгийрүүлж суралцах хэрэгтэй байна. Хувь хүн өөрийгөө цэнэглэж, төгөлдөршүүлэх учиртай. Толгойд буй мэдлэгийг чинь хүмүүс үнэлж, чамайг хүндэлнэ гэдэг аз завшаан. Залуучууд нийгмийн идэвхтэй, ирээдүйнхөө төлөө санаа сэтгэл нь зовдог, тэмүүлэлтэй байвал улс орон хөгжинө.

**-Та ирээдүйдээ хэр итгэлтэй хүн бэ?**

-Монгол Улс маань хөгжих, сайхан ирээдүй ойртож байна. "Азийн бар" улсуудтай эн зэрэгцэн хөгжих итгэл монгол хүн бүрт бий. Надад ч ийм итгэл байна. Ирээдүйдээ итгэлгүй хүн

гэж байдаг юм уу. Бидний тэмүүлж, тэнд л очиж ажиллах юмсан гэж хүсэн мөрөөдөх тэр мөрөөдөл чинь Монголд хэрэгжих том бололцоо бүрдэж байна. Тиймээс нэгдүгээрт, монголчууд бид өөрт байгаа баялгаа үнэлж сурах хэрэгтэй. Энэ их баялгаа хөгжүүлэх санхүүгийн эх үүсвэрээ өөрсдөө олдог байх ёстой. Өөрсдөө эх үүсвэрээ олж байгаагийн хэмжээгээр нөхцөлөө өөрсдөө тавьж чаддаг байх хэрэгтэй. Дандаа бүх юмыг гуйлтын байдлаар бүтээж явж ирлээ. Энэ сэтгэхүй хэзээ ч хөгжилд хүргэхгүй.

Хоёрдугаарт, баялагтаа үндэслэж, хүмүүс өөрсдөө ажилтай болох ёстой. Ажилтай болохын хэрээр улсынх нь орлого нэмэгдэж, орлого нэмэгдэхийн хэрээр цалин өснө. Дараань тэрхүн байраа, автомашинаа авна уу, тэр хүний асуудал. Заавал бүх хүмүүсийг байртай болгох гээд социализмын үе шиг тэгшитгэх нь үр дүнтэй юм уу. Тэгшитгэлээр хэзээ ч дэвшил гардаггүй. Тэгшитгэлээр юм хуваагаад байвал бид хуучин нийгэмдээ л эргэж очно гэсэн үг.

**-Таны хамгийн ихээр эмзэглэж явдаг зүйл юу вэ?**

-Улсынхаа ирээдүйг бодохгүйгээр төр нь олсон хэдээ гарын салаагаар тараагаад байвал эдийн засгийн өсөлт урт удаан настай, тогтвортой байж чадахгүй. Ач, гучынхаа маргаашийг харахгүйгээр иргэд нь төрөөсөө юм нэхээд л байвал улс хөгжихгүй.

**-Таны Хөгжлийн банкт хийсэн гэрээ удахгүй дуусгавар болж байгаа гэж сонслоо. Энэ хугацаанд өөрийн хийж гүйцэтгэсэн хамгийн том ололт амжилтыг юу гэж дүгнэх вэ?**

-Хөгжлийн банкыг хөл дээр нь босгох мэдээж амар ажил байгаагүй. Банкаа хамтын зүтгэлээр бий болгож, нэр хүнд бүхий сайн банкны эхлэлийг тавьж чадсан гэж би хувьдаа боддог. Энэ хугацаанд бид их зүйлийг хийж бүтээлээ. Гэвч энэ ололт, амжилтын дотроос хамгийн том нь эх орныхоо төлөө ихийг хийж бүтээх хүсэл, зорилго, сэтгэлтэй хамт олныг бүрдүүлж чадсан явдал юм. ■

МЭДЭЭЛЛИЙН ИВЭЭН ТЭТГЭГЧ

# “MONGOLIAN ECONOMY”

СЭТГҮҮЛ



10 ЖИЛ

8 САРЫН 30-31  
УЛААНБААТАР ХОТ

ҮЗЭЛ БОДОЛ

## АЗИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАРААС БИДЭНД СУРАХ ЗҮЙЛ БИЙ ЮУ



Хөгжлийн загварын тухай цуврал №2

Түрүүч нь 2012 он 04 сар №007 (017) дугаарт

Б.ЭНХМАНДАХ Доктор /Ph.D./

Зүүн Азийн хөгжлийн загварыг эдийн засгийн хувьд ядуурал, хямралаар нөхцөлдсөн төрийн шууд хатуу хяналт, оролцоотой эдийн засгийн өсөлт дээр тулгуурласан, улс төрийн хувьд сөрөг хүчин болон иргэний нийгмийн сул хөгжлөөс хамаараад хүчирхэг дарангуйлагчтай, нийгмийн хувьд нийгмийн давхараажилт, хүйсийн ялгаварлал ихтэй орнуудын загвар гэж тайлбарладаг учир Барууны орнуудын нийгмийн хөгжлийн загваруудтай харьцуулахад “шохой, бяслаг” мэт хэт их ялгаатай гэж зарим судлаачдын хувьд үздэг тал бий.

Гэтэл үнэн хэрэг дээрээ Европын ЭЗХХБ /OECD/-аас бүр 1994 онд дэвшүүлсэн а/ эдийн засаг, нийгмийн хөгжлийг хослуулах (интеграцичлах), б/ нийгмийн бодлогыг төсвийг хязгаарлах бодлоготой уялдуулах, в/ хүний хүчин зүйлийг нэмэгдүүлж, нийгмийн болон хувийн хариуцлагыг уялдуулан зохицуулах зэрэгт чиглэсэн улс төрийн шийдэл нь Зүүн Азийн нийгмийн хамгааллын тогтолцооны туршлагатай их ойрхон ажиглагдаж байгаа юм. Тиймээс “шохой, бяслаг”-тай харьцуулах бус харин ч “сүү, бяслаг” хэмээн зүйрлэж болох юм хэмээн нөгөө хэсэг эрдэмтэд үзэж байна.

Яагаад гэвэл, Күнзийн үзлээр тэтгэгдсэн Азийн бүх нийтийн сайн сайхан нийгмийн эдгээр орон нийгмийн хөгжилд төрийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангасан төдийгүй, төрөөс нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлж чадсанаараа Барууны орнуудын нийгмийн хөгжлийн үзэл санаа, туршлагад хүчтэй өрсөлдөгчид болон тодорсоор байгаа юм. Хөгжиж буй олон орон, түүний дотор Африк, Өмнөд Америкийн орнууд сүүлийн үед эдгээр орны хөгжлийн загварыг сонирхох болсны учир шалтгаан ч үүнд оршино.

Хөгжлийн загвар болохын хувьд харьцангуй бага судлагдсан эдгээр орны хөгжлийн талаар монголчууд бас сонирхож, Монгол Улс Азийн орон болохын хувьд тэдгээрийн хөгжлийн арга, замаас суралцах сонирхол, хандлага ажиглагдаж байгаа хэдий ч дорвитой судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн судалгаа, шинжилгээний бүтээл гараагүй л байна.

Даяаршлын шинэ эрин үед нийгмийн хөгжлийн загварыг заавал Бүс нутгийн загвараар тодорхойлох шаардлага багасч байгаа ч гэсэн хөгжлийн загварыг

тодорхойлох хүрээнд улс орон бүрээс авах зүйл байсаар байна. Азийн хөгжлийн загварын тухайд хөгжиж буй нийт орнуудын хувьд чухал байж болохыг үгүйсгэж болохгүй. Ганцхан жишээгээр хэлэхэд “хөгжлийн төлөөх нийгмийн хамгааллын тогтолцоо”-г хэрхэн бүрэлдүүлэх вэ гэдэгт тэр бүр бэлэн хариулт олддоггүй. Гэтэл нийгмийн даатгалын хөрөнгө буюу дотоодын хөрөнгийн нөөцийн ашиглалтыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлт, хөгжлөө нөхцөлдүүлж чадсан Өмнөд Солонгосын туршлагыг онцлон нэрлэж болохоор байгаа юм. Тэдний тэтгэврийн сангийн тогтолцоо 1988 онд үүсээд 10 хүрэхгүй жилийн дотор ДНБ-ийхээ зургаа орчим хувьд хүрсэн нөөцтэй болсон юм билээ. Энэ мэт туршлагыг нэн түрүүн судлан нэвтрүүлж болохоор байна.

Мөн Сингапурын “Баялгийн Төвлөрсөн сан”, орон сууцжуулалтын хөтөлбөр, Өмнөд Солонгосын тэтгэврийн сан болон Тайваны эрүүл мэндийн тогтолцоо, Японы ахуйн үйлчилгээ болон Хятад, Хонконгын нийгмийн хамгааллын тогтолцоо гэх зэргээр ялгаварлан авч үзэж, туршлагыг нь гүнзгийрүүлэн судлууштай санагддаг.

Эцэст нь тэмдэглэхэд, даяаршил эдийн засаг, санхүүгийн хэлхээ холбоог хил хязгааргүй болгосноор бүх нийтийн сайн сайхан нийгмийн төлөвшилд саад бэрхшээл учруулах болсныг ч бид тооцон үзэх учиртай. Ганцхан жишээ хэлэхэд, “Төмөр хөшиг” нээгдсэн цагаас хойшхи ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний эмх замбараагүй байдал нь Европын орнуудын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтсон тогтолцоонд хүндрэл, бэрхшээлүүдийг бий болгосноор байгаа билээ. Харин Азийн орнууд энэ талаар төрийн хатуу зохицуулалтыг илүүтэй хийж чадаж байгаа юм. Тиймээс даяаршил бол нийгмийн хөгжилд зарим талаар сөрөг үр дагавартай гэдгийг Азийн орнуудаас суралцаж, бид хөгжлийн загвараа тодорхойлохдоо анхаарах хэрэгтэй болов уу.

Бид Монгол орныхоо хөгжлийн зохистой загварыг олж авч, хэрэгжүүлэхийн тулд аливаа улс орны хөгжлийн загвар, арга замуудыг судлахдаа тэдгээрт бүтээлчээр хандаж, улс орон бүрийн түүх, соёл, улс төрийн тогтолцооны онцлогыг хөгжлийнх нь цаг хугацаа, гадаад нөхцөл байдалтай нь холбон авч үзэж, бүтээлчээр хандан, шинээр сэтгэж боловсронгуй болгох, шинэчлэн засварлаж авч ашиглах шаардлагатай болно. ■



МАЛ АЖ АХУЙН ЗАХ ЗЭЭЛ

## МОНГОЛЧУУД МАХНЫ БИЗНЕСЭЭС ӨНДӨР АШИГ ХҮРТЭХ БОЛОМЖТОЙ

Б.ЦЭЦЭЭ

*Монгол малын махыг гадныхан ихэд сонирхдог. Задгай тал бэлчээр, онгон байгалийн малын мах гээд л. Уг нь монголчууд махаа экспортлоод баяжих сайхан арга зам бий ч олон саад бэрхшээлтэй нүүр тулсаар ирсэн билээ. Өөрөөр хэлбэл, манай мах лабораторийн шаардлага, ариун цэвэр, чанарын шаардлага хангах талд багагүй эрсдэлтэй тулгардаг юм. Чухамдаа энэ л асуудлыг шийдчихвэл монгол мал дэлхийн брэнд болох нөхцөл бүрдэх ажээ. Энэ талаар Монгол Улс, Европын холбооны хамтарсан “Малын эрүүл мэнд, Мал аж ахуйн зах зээл” төслийн Техник туслалцааны багийн ахлагч Иан Лийчтэй ярилцлаа.*

**-Танай төсөл ерөнхийдөө дуусч байгаа юм байна. Төслийн хүрээнд малын ашиг шим, чанарыг сайжруулахын тулд ямар ажлууд хийсэн бэ ?**

-Нэн түрүүнд энэ төсөл хүн амын инженерчлэлийн төсөл биш юм. Бид сургууль, цэцэрлэг, онгоцны буудал бариагүй. Техникийн тусламж буюу зөвлөмж, мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлж өгөхөд төслийн зорилго оршино. Өөрөөр хэлбэл, ихэнхдээ сургалт, практик бэлтгэл болон мэдээллийг түгээн дэлгэрүүлэхэд голчлон анхаарсан.

Үндсэндээ 9.3 тэрбум еврогийн өртөгтэй уг төслийн томоохон хувь буюу 3.4 сая еврог тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан. Тоног төхөөрөмжийн хувьд компьютерийн техник хангамж, програм хангамж, хөргөгч, хөлдөөгчөөс эхлүүлээд тухайлбал, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторит судалгаа шинжилгээний техникүүд багтсан. Тэдгээр нь мал аж ахуйн тухайлбал сүү, мах, арьс шир нэхий, ноос, ноолууран бүтээгдэхүүний

үйлдвэрлэл, нийлүүлэлтийг сайжруулахад нэн хэрэгтэй техникийн тусламж юм. Бидний хувьд үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, улмаар малчдын орлогыг дээшлүүлэх нь гол зорилт байлаа. Бид ихэнх тохиолдолд шууд бус замаар буюу малчид, мал аж ахуйн бүтээгдэхүүн худалдан авагч боловсруулагч, бэлтгэгч, цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн боловсруулагч нарт хамгийн ойр байдаг малын эмч нартай хамтарч ажилласан. Зарим үед малчидтай ч тулж ажиллаж байв.

Шууд болон шууд бусаар төслийн үйл ажиллагааг явуулсан гэж хэлж болно. Нэг жишээ нь малын эмч нарын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон сургалт зохион байгуулсан. Дан ганц ерөнхий мэдлэг бус олон улсын байгууллагаас тодорхойлсон мэргэжлийн ур чадварын түвшний мэдлэг олгож, цаашид олон улсын стандартад өөрсдийн үйл ажиллагааг уялдуулан авч явах чадварыг бий болгоход сургалтын гол зорилго оршиж байв. Мал аж ахуйн салбарын дэлхийн хамгийн том байгууллага нь “Дэлхийн

хүнс, хөдөө аж ахуйн байгууллага” байдаг.

**-Та төслийн зорилго биелэсэн гэж үзэж байна уу ?**

-Европын холбоо болон Засгийн газрын санхүүжилттэй энэ том төслийг хүмүүс амжилттай хэрэгжсэн эсэх хэрэв тийм бол хэр амжилттай байсан бол гэж асууж байгаа байх. Төслийн үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтэд гадна дотны байгууллагууд хяналт шалгалт, мониторинг хийсэн.

Монгол талаас дотоод хяналтыг ХХААХҮЯ хийсэн бол Засгийн газрын аудитын албанаас гадаад хяналт шалгалт явуулсан. Бид мөн өөрсдөө дотоод мониторингийн үйл ажиллагааг мэргэжилтнүүдээрээ хийлгэсэн. Үүний зэрэгцээ Европын холбооны төслийн хяналт шалгалт үнэлгээ хариуцсан тусгай алба сүүлийн үеийн арга техник ашиглан мэргэшсэн мэргэжилтнүүдээр дүгнэлт гаргуулсан. Тэд хэрхэн сургалт зохион байгуулж, төслийн мөнгийг хэрхэн үр ашигтай зарцуулсныг шалгах асаа илүүтэй бодит нөлөөлөөр төслийн үр дүнг хэмждэг юм. ▶

► Өөрөөр хэлбэл, сургалтын агуулга, зохион байгуулалт сайн байлаа. Гэхдээ уг сургалт ямар үр дүнд хүрсэн, хүмүүс өөрсдийн олж авсан мэдлэг мэдээллээ бодит амьдрал дээр ашиглаж, чадаж байгаа эсэх нь хамгийн чухал үр дүн юм. Дээрх орчин үеийн боловсронгуй аргаар хийдэг мониторингийг 2008, 2009 онд мөн хамгийн сүүлд өнгөрсөн жил хийсэн байгаа. Төсөл үр ашиг, нөлөөллийн хувьд бус цаашдын тогтвортой байдлын хувьд маш өндрөөр үнэлэгдсэн. Товчхондоо, энэ төсөл амжилттай хэрэгжиж үр дүнгээ өгсөн гэж хэлэх байна.

**-Манай улсын мал эмнэлгийн лабораторийн оношилгоо шинжилгээг бусад оронтой харьцуулахад ямар түвшинд байна вэ?**

-Товчхон хэлэхэд оношилгоо шинжилгээний түвшин өдөр ирэх тусам сайжирч байгаа. Монголын зарим лаборатори олон улсын стандартад хүрэхүйц байна. Улсын нэгдсэн мал эмнэлгийн лаборатори л гэхэд чадварлаг мэргэжилтнүүдтэй төдийгүй миний дээр дурьдсан орчин үеийн тоног төхөөрөмжийг байршуулсан байдаг. Иймд тэдний хувьд мал аж ахуйн бүтээгдэхүүний дээжийг шинжилж, өчүүхэн жижиг бохирдуулагч бодисыг хүртэл олж илрүүлэх чадвартай. Зарим аймгийн лаборатори ч мөн адил сайн шүү дээ. Төслийн үйл ажиллагааг явуулсан Дархан, Булган, Эрдэнэт, Сүхбаатар болон Зуунмод аймгийн лаборатори өнөөдөр бруцеллэз тэргүүтэй өвчнүүдийг олж илрүүлэх бүрэн боломжтой болсон. Магадгүй

хүссэнээрээ олон дээж шинжилж чадахгүй байгаа ч энэ бол дэлхий дахинд байдаг л асуудал. Дөрвөн жилийн өмнөх буюу төсөл эхлэх үеийн бидний ажиллаж байсан улсын лабораторуудыг харахад нөхцөл байдал өнөөдөр бүрэн өөрчлөгдсөн. Энд дээрх аймгуудын орон нутгийн засаг захиргаа маш их дэмжлэг тусалцаа үзүүлснийг дашрамд хэлмээр байна. Тэдний зүгээс нэмэлт санхүүжилт гаргаж, өөрсдийн нөөц боломжоороо лабораториудаа сэргээн, үйл ажиллагааны цар хүрээг томсгож, стандартаа ахиулсан.

**-Монгол малын онцлог болоод сул тал нь юу байна вэ?**

-Олон малтай ч түүндээ таарсан хангалттай бэлчээр байхгүй гээд л сөрөг талыг нь харвал асуудлууд бий. Гэхдээ Монгол орны мал аж ахуй олон сайн талтай. Тухайлбал, нүүдлийн мал аж ахуйн систем. Мал сүрэг нь сул чөлөөтэй бэлчдэг уламжлал нь өөрөө маркетингийн маш том хөшүүрэг болж, брэндийг хөгжүүлэх үндэс юм. Европын орнуудын дэлгүүрт чөлөөт бэлчээрт бэлчдэг малын махны үнэ арилжааны зорилготой үржүүлсэн малын махнаас харьцангуй өндөр үнэтэй байдаг. Чөлөөт бэлчээр бол Европын зах зээлийг татах хүч шүү дээ. Европт махны чиглэлээр өсгөж үржүүлж буй амьтдыг ямар нэгэн барилга дотор эсвэл хашаанд хоригдмол байдалтай байлгадаг. Тэгэхээр монголчууд малын махаа уудам тал бэлчээрийнх хэмээн Европын зах зээлд сурталчилж чадвал өндөр үнэ хүрэх боломжтой.

Байгалийн гаралтай бүтээгдэхүүн

нь дараагийн нэг чухал хүчин зүйл. Монгол махыг байгалийн гаралтай органик гэж олон хүн хэлдэг. Гэвч энэ тайлбарыг хэрэглэхдээ болгоомжлох хэрэгтэй. Европын ихэнх оронд хэрэв махан дээр байгалийн гаралтай шошго наах бол тэр нь хуульд заасан тодорхой шаардлагад нийцсэн байх ёстой. Монгол махыг одоогоор хуулийн дагуу байгалийн гаралтай гэж тодорхойлсон зүйл байхгүй байгаа. Органик хэмээх үгийг хүмүүс тодорхой ойлголтгүйгээр хэрэглэдэг. Монгол Улс чөлөөт бэлчээрийн мал аж ахуйн системээ улам хөгжүүлж, ирээдүйд байгалийн гаралтай махыг экспортлох бүрэн боломжтой гэж үзэж байна.

**-Ингэснээр Монгол Улс дэлхийн хэрэглэгчдийн анхаарлыг татаж чадах болов уу ?**

-Мэдээж чадна. Манай төсөл энэ тал дээр их ажил хийсэн. Монгол махыг экспортод гаргахын тулд махны хяналт шинжилгээний түвшинг дээшлүүлж энэ талын арга ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай. Ихэнх оронд тухайлбал, Европт гадаадаас импортлогдон оржирж байгаа маханд угсаа гарал, мэргэжлийн малын эмч нараар шалгагдаж, хүлээн зөвшөөрөхүйц аргаар боловсруулсан эсэхийг гэрчилсэн нэг төрлийн гэрчилгээ хавсрагдсан байх ёстой.

Энэ талаар ярихаар манай төслийн нэг хэсэгтэй холбогдож байна. Бид төслийнхөө хүрээнд өнгөрсөн жил дэлхийд танилцуулсан илрүүлэлтийн системтэй нэлээд төстэй компьютерт суурилсан таньж илрүүлэх, бүртгэлийн системийг Монголд өгсөн. Ингэснээр ►►





DISCOVER MONGOLIA-2012

## МОНГОЛЫН НҮҮРСЭНД ИРЭЭДҮЙ БИЙ ЮУ

Хятадын эдийн засаг өөдрөг байвал Монголын нүүрс уул уурхайн нэрийн хуудас хэвээр үлдэх аж.

**Б.БАЯРТОГОХ**

Манай улсын эдийн засгийн зүтгэх хүч нь нүүрс. Тиймээс улсын төсвийн орлогод зэс бус нүүрс жин дарах боллоо. Гэрлийн хурдаар нүүрсний экспорт нэмэгдэж, гадаад худалдааны 98.5 хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзлэх болов. Тодруулбал, чулуун нүүрс нийт экспортын 46.8 хувийг бүрдүүлж байна. Өнөөдөр нүүрсний салбарт төрийн өмч давамгайлсан “Багануур”, “Шивээ овоо” хувьцаат компани, орон нутгийн өмч давамгайлсан жижиг гэх тодотголтой “Тавантолгой”, “Баянтээг”, “Могойн гол” хувьцаат компани, хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай “Тавантолгой” хувьцаат компани, “Энержи ресурс” ХХК, “МАК”, “Чинхуа-МАК-Нарийн сухайт”, “Саусгоби Сэндс” ХХК зэрэг 40 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Тэд улсдаа хамгийн өндөр татвар төлөгч, нийгмийн хариуцлагатай эдийн засгийн тулах хүч, олон мянган хүнийг ажлын байраар ханган шингээх чадвартай, өндөр цалин олгогчид. Зөвхөн нүүрсээ түүхийгээр болон хагас боловсруулсан байдлаар нь Хятадад зараад зогсохгүй, түүнтэйгээ тэнцэхүйц үр өгөөжийг эдийн засагт авчирч байгаа нь бодит үнэн. Нэг үгээр хэлбэл, эдийн засгийн хөтөлгөч хүч нь нүүрсний салбарынхан гэдэгтэй маргах шалтгаан үгүй ээ.

“Нүүрс-Монголын эдийн засгийн эрчимтэй хөгжлийн хурдасгуур” хэ-



мээн “Коал Монголиа-2012” олон улсын чуулга уулзалтын оролцогчид онцолж байсан. Гэхдээ, нүүрсний гүн боловсруулалтыг, байгаль орчны асуудлыг, орон нутгийн хөгжлийг нүүрсээр овоглосон компанийн эздээс асуух нь нийгмийн захиалга билээ. Газрын хэвлийд он удаан жил дарагдсан эртний аварга мод өдгөө эдийн засгийг услах “хар нүүрс” аж. Түүгээр Монголын эдийн засаг “хөлжиж”, нүүрсний шидээр Монгол Улс Хятадын хамгийн ойрын, хамгийн хямд ханган нийлүүлэгч болсныг бид мэддэг мөртлөө өмнөд хөршдөө нүүрсээ нийлүүлсээр.

Дэлхийн хамгийн том зах зээл нь Хятад, нүүрсийг “уж” буй “ёроолгүй сав” гэж хэлж болно. Хятадаас илүү

сайн сонголт, түүнээс илүү хялбар, зардал багатай зах зээл өнөөдөртөө манайд алга.

Тиймээс нүүрсний хайгуул хүрээгээ тэлсээр. ЭБЭХ-ний дэд сайд Ц.Гарамжав “Өнгөрсөн онд Эрдэс баялгийн зөвлөлөөр давхардсан тоогоор 23 нүүрсний ордын нөөцийн тайланг хэлэлцэн 7.8 тэрбум нөөцийг шинэчлэн баталсан” гэв.

Манай улсын нүүрсний геологийн таамаг нөөц 175 тэрбум тонн. Цаашдаа 175+... гэсэн магадлал нүүрсний салбарт хамгийн өндөр болохыг тус салбарын сайд нь онцолсон. Тэгвэл нөөцийн хязгаарлалтгүй, бас татваргүй, түүхийгээр нь худалдаж болох нүүрсэнд ирээдүй бий юу.

Нүүрснийхээ нөөцөөрөө дэлхийн ▶

► улс орнуудын эхний 15-т багтдаг Монгол “Нүүрсний Саудын Араб болно” гэдэгт та хэр итгэлтэй байна вэ. Улсын хэмжээнд нүүрсний 85 ордтой гэсэн статистик мэдээ бий. Гэхдээ, 85 орд нь нөөц болоод нүүрсний чанараасаа хамаараад эрс тэс. Монголын нүүрсийг бусдаас илүүтэй сонирхож буй худалдан авагч бол манай мөнхийн хөрш Хятад. Тэд Монголоос нүүрс авахгүй байснаараа

төлөв ажиглагдаж байгааг Худалдаа хөгжлийн банкны Ерөнхийлөгч Рандолф С.Коппа “Нүүрсний зах зээлийн стратегийн хөгжил” илтгэлдээ тэмдэглэв. Тэрбээр Монголын нүүрсний өрсөлдөх чадварыг хэмжихдээ ирэх 2016 он гэхэд Хятад руу экспортолдог Монголын коксжуулсан нүүрсний хэмжээг 50 сая тонн гэсэн урьдчилсан таамаглал дэвшүүлсэн. Өнгөрсөн онд нэг тонн нүүрс 100 ам.долларын

худалдааг сэвхийтэл өөд нь татсан билээ. Гэхдээ, өсөлтийн цаана уналт байгааг С.Коппа сануулсан байгаа. Уналт нь зөөлөн газардалт байж чадах уу гэсэн хариултыг тэр бидэнд үлдээв. Учир нь, коксжуулсан нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр буурч байгаа, Хятадын Төвбанк бодлогын хүүгээ хөдөлгөх болсон, үйлдвэрлэлийн өсөлт буурч байгаа нь манай нүүрсний салбарт ч өсөлт бус алдагдал дагуулж мэдэх аж. Тиймээс нүүрсний түргэмгийлэл богино настай ч байж болох тал ажиглагдаж байна. Гэхдээ түр зуурын саатал байхыг ч үгүйсгэх аргагүй.

6.4 тэрбум тонн нүүрсний нөөцтэй “Эрдэнэс Тавантолгой” компани 2013 оны эхээр хоёрдогч зах зээлд хувьцаагаа арилжаалахаар бэлтгэж байна. Тус компани 162.3 тэрбум тонн нөөцтэй Монголын нүүрсний баялгийн ердөө л үйрмэг нь. Урд хөрш өнгөрсөн хугацаанд манай томоохон хөрөнгө оруулагч байсаар ирсэн. Өнгөрсөн жил л гэхэд 6.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Тэгвэл сүүлийн 10 жилийн хугацаанд оруулсан нийт хөрөнгө оруулалтыг тоогоор хэлбэл, нэлээдгүй өндөр тоо гарах нь тодорхой. “Өмнөд хөршийн нийт нүүрсний импортын 11 хувийг Монголын гаралтай нүүрс эзэлдэг. Хятад улс руу экспортолж буй нүүрсний өнгөрсөн оны хэмжээг 2010 онтой харьцуулбал 23 хувиар өссөн” гэж БНХАУ-ын Элчин сайд Ван Сяолун “Коал Монголиа” чуулганы үеэр тэмдэглэсэн билээ.

Тэд манай улсаас авах нүүрсний импортын хэмжээгээ нэмэгдүүлэх сонирхолтой байгаа ч Монголын нүүрсний өртөг нэмэгдэж, нүүрсэндээ экспортын татвар шингээх асуудал яригдаж байгаа нь сүүлийн үед дотоодын экспортлогч компаниудад “цочроо өгөв”. Нүүрсэнд экспортын татвар тогтоосноор манай эдийн засагт эргэлдэх мөнгөний хэмжээ багасч, Монголын өртөг өндөртэй нүүрсийг урд хөрш худалдан авах сонирхол буурна гэж уул уурхайн салбарынхан үзжээ. Экспортын татвараас гадна ирэх жилүүдэд Хятадын эдийн засаг цэлмэг байхгүй нь гэсэн айдас Монголын нүүрсний ирээдүйд, одоогийн экспортын хэмжээнд цэг тавьж мэдэх тул тус салбарынханд ►



“гал алдана” гэдэг юу л бол. Харин урд хөршид Австрали, Индонези гэсэн хоёр том ханган нийлүүлэгч бий. Монголын нүүрс тэдэнтэй өрсөлдөж байна. Тэгвэл Монгол Улс урд зүг рүү нүүрс экспортлохгүй байснаар юу хожих вэ. Мэдээж, Монгол Улс хохирч, эдийн засгийн өсөлт удааширч, төсвийн орлого саарахыг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа хэллээ.

## Болгоомжлол

Монголын нүүрсний ирээдүй ойрын жилүүдэд Хятадын эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэлийн хөгжлөөс шууд хамааралтай байхаар

дундаж үнэтэй байсан бол 2010 онд нэг тонн нүүрс 50 ам.доллар болтлоо буурсан. Нэг үгээр хэлбэл, Хятадын эдийн засаг өөдрөг байвал ирэх өдрүүдэд тонн нүүрсний үнэ 100 ам.доллараас өснө гэсэн дүгнэлтийг С.Коппа өгөв.

Бидний өмнөд хөрш дэлхийн коксжуулсан нүүрсний гол хөдөлгүүр аж. Өнгөрсөн онд л гэхэд Хятадын төмөрлөгийн үйлдвэрлэл есөн хувиар өсөхөд дэлхийн үйлдвэрлэл зургаан хувийн амжилт үзүүлсэн. Хятадын эдийн засаг өнгөрсөн онд 8.9 хувиар өсөж, Монголын эдийн засаг 17.5 хувиар хурдсаж дэлхийд “гайхуулав”. Зүүд гэмээр манай эдийн засгийн өсөлтийг зүлгүүрдэх нүүрсний экспортын хэмжээ ч гадаад

► эрсдэлээ тооцсон болгоомжлол төрүүлжээ. Гэтэл нүүрснээс экспортын татвар авах сонирхол шургуулах боллоо. Монгол нүүрснийхээ өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд, түүнийгээ үнэд хүргэхэд экспортын татвараар торгох бус харин дэд бүтэц, тээвэрлэлтийн асуудлыг нь нэг мөр шийдэж, боловсруулалт, коксхимийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн бий болгоход анхаарах шаардлагатай байгааг гаднын хөрөнгө оруулагчид өгүүлсэн. Нүүрсний бүтээгдэхүүний /баяжмал, кокс, давирхайн боловсруулалт, шингэрүүлсэн түлш/ экспортыг бүх талаар нь дэмжинэ гэдгээ манай Засгийн газар илэрхийлсэн ч өнөөг хүртэл нүүрс тээвэрлэх нэг км ч төмөр замын ажил эхэлсэнгүй.

## Хонгилын үзүүрт гэрэл улалзав

Монголын нүүрсний экспорт ирэх жилүүдэд саарч, түүнийг худалдан авах сонирхол Хятадад буурах ч магадгүй эсрэгээрээ эдийн засаг сэргэж, эрэлтээ гүйцэхгүй ч байх хэд хэдэн шалтгаан бий. Хятадын хөгжлийн 2012-2017 оны төлөвлөгөөнд тэмдэглэсэнээр тус улсын бүтээн байгуулалт АНУ-тай харьцуулахад найм дахин их байна. Хотжилтын өсөлт 48-54 хувь болтлоо өсөхийн хэрээр бусад орон сууц, барилгажилт нэмэгдэх аж.

“Хятадын ирэх таван жилийн төлөвлөгөөнд гангийн эрэлт жилд

зургаан хувиар өсөх магадлалтай байна. Хэдий эдийн засгийн зарим үзүүлэлт сайнгүй байх боловч коксжуулсан нүүрсний импортын таамаглалаас үзвэл дотоодын нүүрсний олборлолт хамгийн ихдээ хүрнэ гэж үзэж байна” хэмээн “Нүүрсний зах зээлийн стратегийн хөгжил” илтгэлд дурджээ. Хятад нь одоогоор гангийн үйлдвэрлэлдээ зориулж жилдээ 380 сая тонн коксжуулсан нүүрс нийлүүлдэг. Ихэнх нь газар доорх уурхайнууд. Зардал болон аюулгүй байдлын асуудлууд өсөж байгаа тул нүүрсийг импортоор авах хүслээ өмнөд хөрш орхиж чадахгүй нь гэсэн дүгнэлтийг эндээс харж болохоор. Ирэх таван жилд Хятад улс жилдээ 70-100 сая тонн хүртэл, эсвэл бүр 200 сая тонн хатуу коксжуулсан нүүрс импортолно гэсэн мэдээ бий. Тэгвэл, Энэтхэг улс жилдээ 40- 60 сая тонн импортлоно гэх таамаг бий. Магадгүй, Монголын дараагийн том зах зээл Хятадаас гадна Энэтхэг байхыг үгүйсгэх аргагүй юм.

Гэхдээ урд хөршид нүүрсний зах зээлээ төвлөрүүлж, байр сууриа баталгаажуулан, өндөр чанартай коксжуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тээвэрлэлтийн зардлаа бууруулсан тохиолдолд экспортын татвараас дутахгүй ашгийг монголчууд хүртэх боломжтой юм байна. Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүд бий болж байгаа ч нүүрс Азидаа эрчим хүчний “хаан” байна гэсэн дүгнэлтийг хамгийн сүүлд болсон “Coaltrans Mongolia” олон улсын бага хурлын үеэр

“Пийбоди Энержи” компанийн Монгол ба Энэтхэгийг хариуцсан Ерөнхийлөгч Аршад Саиед онцолсон билээ.


Түүнчлэн “Дэлхийн эрчим хүчний хэрэгцээний 50 хувийг нүүрсээр хангаж байна. Үлдсэн хэсгийг нь цөмийн эрчим хүч болон хийн түлш эзэлдэг. Сүүлийн 10 жилийн хугацаанд эрчим хүчний гол түүхий эд нь нүүрс байлаа. Азийн эрчим хүчний эрэлт хэрэгцээг гол төлөв нүүрс хангаж байна. Дэлхийн эрчим хүчний анхдагч хэрэглээний 30 хувийг дангаараа нүүрс эзэлж байгаа. Өнөөдрийн байдлаар нүүрс дэлхийн нийт эрчим хүчний 49 хувийг үйлдвэрлэсээр байна. Нүүрс бол дэлхийн гол түлш. Тиймээс Монголд эрчим хүчний диваажин байгуулах боломж бий” гэж Аршад Саиед Монголыг “магтав”.

Манайх 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад элсэж, 157 оронтой худалдаа явуулах эрхзүйн орчин бүрдүүлсэн ч өмнөд хөршөөсөө өөр зах зээлийг нээж чадаагүй байгаа Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Н.Энхтайван тайлбарласан юм. Тэрбээр “Хятад өөрөө дэлхийн хамгийн том түүхий эдийн зах зээл. Тэр дотроо уул уурхайн бүтээгдэхүүний. Дэлхийн бүх орон Хятад руу бүтээгдэхүүнээ экспортлохын тулд өрсөлдөж байхад бид Хятадад өгөхгүй гэвэл аманд орсон шар тосыг хэлээрээ түлхэхтэй адил юм болно. Тэгээд ч давуулаад өгөх зах зээл байтугай боломж нөхцөл нь ч алга. Хамгийн гол баримтлах бодлого бол гаргаж байгаа бүтээгдэхүүндээ хэрхэн нэмүү өртөг шингээх, үнэ хүргэх вэ гэдэг л чухал” гэлээ.


Дэлхийн зах зээлд нүүрсний эрэлт хэрэгцээ өсөж байна. Тухайлбал, 2010-2035 он хүртэл нүүрсний эрэлт хэрэгцээ 60 хувиар нэмэгдэх төлөвтэй буй аж. Нүүрсний үйлдвэрлэл 2035 гэхэд 65 хувиар өснө гэсэн таамаг ч бий. Нүүрсийг дэлхийн 50 оронд олборлож байна. Эдгээр 50 улсын нүүрсний салбарт нийтдээ 70 гаруй сая хүн ажиллаж байгаа гэсэн тоон үзүүлэлт бий. Хятадын эдийн засаг өөдрөг байвал Монголын нүүрс уул уурхайн нэрийн хуудас хэвээр үлдэх аж. ■



Нүүрс олборлолт, экспорт /сая.тонн/



Төмрийн хүдэр үйлдвэрлэлт /мян.тонн/




Монгол Улсын төсөвт уул уурхайн салбараас оруулж буй орлого/тэрбум төгрөгөөр


	Төвлөрүүлсэн орлого	Өсөлтийн хувь
2009 он	428.2	
2010 он	873.76	+68.30%
2011 он	1094.5	+25.30%

Уул уурхайн салбараас нийт 17 төрлийн татвар, хураамжаар улсын төсөвт орлого төвлөрүүлж байна.

Уул уурхайн үйлдвэрлэлийн эдийн засагт эзлэх хувь хэмжээ /хувиар/



Дотоод зах зээл дээрх нүүрсний хэрэглээ/хувиар/



Эх сурвалж: ЭБЭХЯ, Ашигт малтмалын газар, Сангийн яам

## ОЮУТОЛГОЙН БУЛАН

## 90+...

## Б.АЛТАЙ

Монголчууд есийн тоог билэгддэг. Есөн цагаан сүлдэндээ шүншиглэн мөргөдөг. Сайн сайхан бүхнийг есөн нүхтэй цацлаараа домнодог. Ертөнцөд Монголын сүр хүч, ухааны далайг сонордуулсан Чингис хаан есөн хөлөг баатартай. Түүндээ итгэж Тэмүүжин Их Монгол гүрнээ байгуулсан. Монголчууд бид есийн тоогоор хувь заяагаа тэгшилдэг өвөрмөц уламжлалт сэтгэлгээтэй ард түмэн билээ. Тэгвэл Монголын эдийн засагт хүчтэнхээболсон, айсуйцагийн хөгжлийг зөгнөж буй “Оюутолгой”-н төслийн талаарх есөн зүйлийг танд хүргэж байна. Найр, наадам амралт хавтгайрсан дэлгэр цаг иржээ. Дэнж хотойлгон дэвэх хүчтэй бөхчүүдтэй, хурмастын салхийг зүсэн давхих хүлэг морьдын төвөргөөнтэй, онч мэргэнээ гайхуулсан эрхий мэргэн харваачтай Монгол нутагт есөн есийн наян нэгэн уньтай өргөө цагаан гэрт “Эртний сайхан” дуу шуранхайлна. Ийм цагаар “Оюутолгой”-н тухай хүүрнэх л хэрэгтэй бус уу.

**Нэг:** Манай улс 50 сая толгой малтай. Нэг хүнд ногдох малынхаа тоогоор дэлхийд аравдугаарт, нэг хүнд оногдох махны жилийн дундаж хэрэглээгээрээ арваннэгдүгээрт явна. Тэгвэл, эрдэс баялгийн нөөцөөрөө мөн л дээрх амжилтыг үзүүлээд байна. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани ирэх оны эхний улиралд хоёрдогч зах зээлд хувьцаагаа арилжаалахаар болсон. Харин “Оюутолгой” компанийн үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт ирэх онтой уралдан шуударч, үйл ажиллагаа нь цэцэглэх нээ. Нэг үгээр хэлбэл, “Оюутолгой” төсөл тун удахгүй үйлдвэрлэлээ эхлүүлж, анхны бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд хүргэх түүхэн цаг ойртож байна. Одоогийн байдлаар төслийн

үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт 90 хувьтай байгаа аж. Өөрөөр хэлбэл, 90+... гэсэн зарчмаар Өмнийн говьд бүтээн байгуулалт өрнөж байна.

**Хоёр:** Хэдхэн хоногийн дараа дэлхий нийтээрээ Олимпоор амьсгалах мөчид “Оюутолгой” төсөл 100 хувь гэсэн улаан туузыг хайчилна. Лондоны тэнгэрт Монголын туг далбаа намирах түүхэн мөчтэй зэрэгцэн уурхайн бүтээн байгуулалт 100 хувийн амжилт руу тэмүүлнэ. Уул уурхайн салбарт шинэ мянганы хуудсыг нээх дэлхийн төсөл Монголын хөрсөнд үйлдвэрлэлээ явуулж, үр дүнд нь Монгол Улс улам хурдацтай хөгжих боломж бүрдэх аж.

**Гурав:** Монгол Улсын эдийн засгийн эрчимтэй өсөлт ч үргэлжилсээр. Энэ оны эхний улирлын байдлаар гэхэд 16.7 хувиар өсчээ. Эдийн засаг ийнхүү өндөр өсөлттэй гарахад Оюутолгойн бүтээн байгуулалт нийт эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлж байна хэмээн Дэлхийн банкныхан тайлбарлав.

**Дөрөв:** Монголын Засгийн газарт 700 сая ам.долларыг хэдийнэ төлсөн “Оюутолгой” компанийн барилгын үе шат 90 хувьтай явааг дээр өгүүлсэн билээ. Төслийн бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын гэрээнд тооцсон хугацаанаас зургаан

сарын өмнө дуусч, наймдугаар сараас “Оюутолгой” өөрийн брэнд бүтээгдэхүүнээ гаргана. Мэдээж, уурхайн анхны бүтээгдэхүүний дээж Монголын түүхэнд нэгэн шинэ үеийн музейн үзмэр болон Монголдоо үлдэх нь тодорхой буй за.

**Тав:** “Оюутолгой”-н уурхай ашиглалтад орохоос өмнө өнөөдрийн байдлаар манайд 7.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Хөрөнгө оруулалтын дүнд Монголын эдийн засагт эргэлдэж буй нийт мөнгөний 30 хүртэлх хувийг “Оюутолгой” төсөл “олборлож байна”. “Оюутолгой” гэсэн зорилтот зах зээлд дотоодын 1900 орчим ханган нийлүүлэгч компани тоглолт хийж байна. Тэднээс “Оюутолгой” компанийнхан 1.7 их наяд төгрөгийн бараа үйлчилгээг авсан гэсэн тоон мэдээ бий. Тооны ард чанар, үр ашиг, аюулгүй үйл ажиллагаа, баталгаа байдаг. Тус компанийн зарчим ч ийм гурван төгөлдөршилтэй юм билээ.

**Зургаа:** “Тогтвортой хөгжил нь урт удаан хугацааны төсөөлөл, үзэл бодолтой байхыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжил нь ирээдүй үеийнхээ хэрэгцээг бууруулалгүйгээр өнөө үеийн хэрэгцээг хангах үйл явцыг илэрхийлнэ. Тогтвортой хөгжлийн талаарх бидний зорилго нь эрхэлж буй ▶





► бизнесийн салшгүй чухал хэсэг бөгөөд бид байгаль орчин, нийгэм болон эдийн засгийн хэрэглээний тэнцлийг хангах замаар тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх чин эрмэлзлэлтэй байдаг” хэмээн “Оюутолгой” цахим хуудастаа / [www.ot.mn/](http://www.ot.mn/) тэмдэглэжээ.

Энэ зорилгодоо хүрэхийн төлөө тус компани Өмнөговь аймагт 30 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт зарцуулаад байна. Зөвхөн орон нутгийн хөгжилд зориулж улсын төсвөөс дутахгүй хэмжээний мөнгийг өгчээ. Гэхдээ зүгээр нэг мөнгө өгөөд зогссонгүй 70 км урттай гүний усны хоолой, олон улсын нисэх онгоцны буудал, 35 МВт хүчин чадалтай цахилгааны шугам бариад эхэлжээ. Мөн 1.6 их наяд төгрөгийн төсөвтэй хүдэр баяжуулах үйлдвэрийн суурийг тавьсан байна.

**Долоо:** Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт энэ оны хоёрдугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 42.4 хувиар өсөхөд экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 11.8 хувиар, импортын гол нэрийн бараа, түүхий эдийн биет хэмжээ 43.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн гэж Монголбанк онцоллоо. Экспортын бараа бүтээгдэхүүнд уул уурхайн бүтээгдэхүүн жин дарсан хэвээр л байна. Нийт экспортын 40.6

хувийг чулуун нүүрс, 22.5 хувийг зэсийн баяжмал, 12.2 хувийг төмрийн хүдэр ба баяжмал, 8.5 хувийг боловсруулаагүй нефть эзэлсэн байна. Тэгвэл “Оюутолгой” үйлдвэрлэл эхэлж, үйл ажиллагаа нь жигдрээд ирэхээр гадаад худалдааны экспортод томоохон өөрчлөлт гарна хэмээн мэргэжилтнүүд үзэж байна. Учир нь, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн төрөх боломж харагдаж байгааг тэд тэмдэглэсэн.

**Найм:** “Өнөөдөр Оюутолгой орд зэрэг ашиглалтад ороогүй мөртөө манай зах зээлд эргэлдэж байгаа гурван төгрөг тутмын нэг нь Оюутолгойтой холбоотой гэдэг ойлголт бий. Мөнгө тараах нь зөв гээгүй л дээ, гэхдээ энэ тарааж байгаа мөнгө чинь ашиглалтад арай ороогүй байгаа Оюутолгойн мөнгө бишгэжүү хэмээн нийтлэлч Б.Баабар асууж байна. Тэрбээр, Дотоодын хөрөнгө оруулалт гэж байдаггүй юм. Энэ бол нэг халааснаасаа нөгөө халаас руу мөнгө хийж буй хэрэг. Энд “оруулаад” байгаа юм алга. Чи дэлгүүр нээх гэвэл байгаа гуанзаа зарна, эсвэл байр байшингаа зарна. Эвсэл зээл авна. Энэ улс дотор л явж буй дотоод гүйлгээ байгаа биз дээ. Хөрөнгө шинээр орж ирэхгүй байна. Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг нь энэ саван дотор

төлөвлөөгүй байсан хүний мөнгө орж ирээд капитал үүсгэлцээд эхэлж байна шүү дээ. Гаднаас орж ирсэн тэр мөнгө эргэлдээд ашгаа өгөхөөр цаад эзэнд нь ч ашигтай, оруулсан улсад ч ашигтай. Иймээс л аливаа улс орон гадаадын хөрөнгө оруулалтыг татахын төлөө зүтгэж булаацалддаг. Өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалтыг хамгийн их татсан орон АНУ, хоёрдугаарт Хятад ордог гэлээ.

**Ес:** “Оюутолгой” төсөл монголчуудад эрсдэлгүй тоглоом, харин хөрөнгө оруулагчдад “хатуу самар” болохыг “Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Камерон Макрей нэгэнтээ хэлсэн билээ. Түүнчлэн монголчууд “Оюутолгой” төслөөс ахиу ашиг “шанагадаж”, хүлээж буй ашгийнхаа хэмжээг нэмэгдүүлэх, түүний хэрээр эдийн засгаа хөгжүүлэх сонирхолтой. Учир нь, бид баялгийн эзэн гэсэн монгол хүний итгэл үнэмшил “Оюутолгой” компанийн 51 хувиас ч илүү үнэ цэнэтэй агаад хүчтэй аж. Энэ оны дөрөвдүгээр улирлаас тус компани анхны хүдрээ боловсруулж эхэлнэ. Гучин гурван сарын хугацаанд хийхээр төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлаа 27 сарын дотор оюутолгойчууд сүндэрлүүлж чадлаа. ■

БРЭНД

## БРЭНДТЭЙ БОЛ БУРХАНААС ГУЙХ ЮМГҮЙ

Та худалдан авагчийнхаа тархинд өөрийн эерэг орон зайг эзэлсэн л бол хүссэн үнээ тулгах боломжтой”

### Э.БОЛД

Брэнд гэдгийг хүн төрөлхтөн 2000 гаруй янзаар тайлбарласан байдаг. Харин XXI зуунаас брэндийг асар өргөн хүрээнд авч үзэх болжээ. Тухайлбал, эрүүл ахуй, эдэлгээ даах чадвар, техник технологийн давуу тал, өнгө үзэмж гээд бүх зүйл хамгийн сайнаараа брэндэд шингэсэн байх ёстой. Үүнийг чанар гэх үгээр төлөөлүүлэн ойлгож болох юм. Гэхдээ өнөөгийн эдийн засгийн тогтолцоо маш их өрсөлдөөнийг зах зээлд бий болгохын хэрээр бараа бүтээгдэхүүний чанар өндөр зэрэглэлд хүрч байна. Тухайлбал, “I Phone”, “Samsung Galaxy” хоёр утасны технологи, өнгө үзэмж, үнэ, чанар нь нэг нь нөгөөгөөсөө дутах зүйлгүй. Ийм үед худалдан авагчид сонголт хийх бэрхшээлтэй тулгардаг байна.

20 эсвэл 30 жилийн өмнө аливаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй улс орон, үйлдвэрлэгч компани худалдан авагчдад заавал таалагдах албагүй байжээ. Чанар л чухал байв. Харин зах зээлийн өрсөлдөөн дунд ижил төрлийн бараа бүтээгдэхүүний чанар дээрх мэт адилхан болсон нь хэрэглэгч үйлдвэрлэгчээс илүү ихийг шаардах болсон байна. Тиймээс худалдан авагчид өөрсдийн сонголтоо хийхийн тулд үйлдвэрлэгч компанийн нэр хүнд, компанийн засаглал, үйл ажиллагааны ил тод байдал, мөн тухайн компанийн үнэт зүйл нь юу вэ гэдэгт ихээхэн анхаардаг болжээ.

Таногоочин байлаа гэхэд хураасан ногоогоо захын аль нэг лангуун дээр өрчихөөд хэнхээсээ ирж авах вэ хэмээн хүлээдэг цаг хэдийнэ өнгөрчээ. Тантай адилхан ногоо тарьсан олон

хүн хажууд чинь бий. Тэднээс Та давуу талаа тодорхойлж, түүндээ тулгуурлан маркетинг хийх хэрэгтэй гэдгийг мэргэжилтнүүд зөвлөж байна. Хэрвээ өөрийн давуу талаараа зөв сурталчилгаа хийж чадвал Та брэнд бий болгож чадна гэсэн үг. Монгол Улс брэнд “төрүүлэхэд” зарим нэг асуудал хүндрэлтэй байгааг МҮХАҮТ-ын санаачилгаар хэрэгжиж буй “Үндэсний брэндийн маркетинг” хөтөлбөрийн удирдагч Stephen Креер хэлсэн юм.

### Хамтаараа “лаг”

Монголын үндэсний брэндийг бий болгоход тулгамдаж буй асуудлын нэг нь эв хамтын нэгдэл. Үндэсний хэмжээний нэр хүндийг бий болгох гэж байгаа бол Монгол Улс бултаараа хөдлөх хэрэгтэй. Тухайлбал, томоохон компаниуд салбар салбараараа нэгдэх хэрэгтэй гэдгийг учир мэдэх хүмүүс хэлж байна. Өнөөдөр монголчууд бид хувиа бодож, довоо шарлуулах үзэлд хэт автаад байгааг хэлэх олон хүн бий. УИХ-ын гишүүн Д.Энхбат “Бид урьд нь нийтийн юмыг л дээдэлдэг байсан бол өнөөдөр нийгмийн, нийтийн эд хөрөнгийг юман чинээ бодохгүй байна. Бүгдийг л хувьчлах гээд байдаг. Хууль нь хүртэл тийм байна. Тухайлбал, танай нутгийн гол хордчихлоо. Та шүүхэд очихоор “Өөрөө хордсон уу” гэж асуудаг. Хэрвээ Та хордоогүй бол шүүх таныг хохирогч биш гэж үзээд хэргийг авч хэлэлцэхгүй. Та хохирдоогүй л бол шүүхээр явах эрх байхгүй гэсэн үг.

Тэгвэл бидэнд Туул гол ширгэх, Богд уулд түймэр асах хамаагүй юм байна л даа. Эндээс харахад л хамтын, нийтийн эрх ашиг гэх зүйл алга. Энэ нийгэмд амиа л бодвол тэргүүний мундаг хүн юм байх” хэмээн ярилцлага өгчээ.

Энэ мэт хувиа хичээсэн үзэл үндэсний брэндийг хойш татсаар байна.

Өнөөдөр Швейцарь орны нэрийг сонсоход л хүмүүст худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, амьдрах газраа солих эсвэл аялал жуулчлалаар явах шийдвэрт нөлөөлөх дүр зураг буудаг гэсэн судалгааг Европын нэгэн судалгааны байгууллага хийжээ. Швейцарьчууд энэ нэр хүндийг олж авахын тулд багагүй зүтгэл гаргасан байна. Инээдтэй ч гэмээр юм уу нэг жишээ дурдахад швейцарьчууд нэгэн онигоог гаднаас ирсэн жуулчин бүрт ярьж өгдөг байсан аж. Тэр нь . . . “Бурхан “Танай нутгийн хүмүүс ер нь сүмд их очих уу” гэж нэгэн швейцарь эрээс сониучиржээ. Гэтэл мань хүн өөдөөс нь, “Манай оронд амьдрал сайн болохоор ертөнцийн эзнээс гуйх юм гарахгүй ээ” гэсэн гэдэг. Энэ нь нэг талаар жуулчдын далд ухамсарт нөлөөлөх маркетингийн арга бол нөгөө талаар швейцарь хүн бүр үндэстнийхээ нэр төрийг өндөрт өргөхөд маш бага зүйлээр ч хамаагүй тусалж болохын тод жишээ юм. Хүний далд ухамсарт ийм байдлаар нөлөөлөх нь хүний үйлдэлд нөлөөлөх хамгийн шилдэг арга болохыг маркетингийн менежерүүд хүлээн зөвшөөрдөг. ▶



## ► Гарц буюу огт байхгүй гэдэг давуу тал

Заримдаа хэний ч мэдэхгүй улс байна гэдэг маш том давуу тал болдог ажээ. Stephen Kreppel “Өнөөдөр гаднын ихэнх оронд Монголын талаар сайн, муу ямар ч ойлголт байхгүй. Тухайлбал, Хятад улс тийм ч найдвартай гэх үзэл бодлыг хэрэглэгчдийн тархинд нь суулгаж чадаагүй. Үнэхээр найдвартай бараа үйлдвэрлэсэн ч худалдан авагчид шууд хүлээн зөвшөөрөхгүй. Харин Герман, Япон зэрэг улс өөрсдийгөө илүү найдвартай гэдгийг олон улсад таниулж чадсан. Тиймээс лангуун дээрх бүх бараа адилхан чанартай, үнэтэй байлаа ч гэсэн худалдан авагчид Германы бүтээгдэхүүнийг сонгодог. Харин Монголын талаар найдвартай аль эсвэл найдваргүй гэх ойлголтын аль аль нь гаднынхны дунд байхгүй. Энэ бол том давуу тал. Тиймээс Монгол Улсад үйлдвэрлэсэн юм бүхэн найдвартай гэх ойлголтыг бий болгох хэрэгтэй” гэв.

Тэгвэл найдвартай, чанартай ойлголтыг бий болгохын тулд маркетинг хийх ёстой. Stephen Kreppel-ын хэлсэнчлэн органик буюу “ногоон” бүтээгдэхүүн хэрэглэгчдийг татах хамгийн гол хөшүүрэг болоод байгаа өнөө үед байгальтайгаа зохицож амьдардаг нүүдэлчин монголчуудын энгийн амьдрал л өөрөө олон улсад брэнд болох аж. Гэхдээ хамгийн чухал асуудал нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн дэлхийн стандартад нийцсэн байх учиртай. “Бид Монголд үйлдвэрлэсэн ноолууран цамцны шошгонд 100 хувь ноолуур гэж

бичээд хэн ч итгэхгүй. Учир нь, өнөөдөр бүх л ноолууран цамц 100 хувь гэсэн бичигтэй байгаа. Харин бид шошгон дээр бичсэн 100 хувь гэсэн үгийг баталгаажуулахын тулд хамгийн түрүүнд дэлхийн хэмжээний стандартын шаардлага хангасан гэдгээ нотлох гаднын томоохон үнэлгээ тогтоодог хараат бус агентлагуудаар өөрсдийн бүтээгдэхүүнийг хүлээн зөвшөөрүүлэх нь чухал. Дээрээс нь хэрвээ бид зорилтот хэрэглэгчээ зөв тодорхойлж, тэд юу хүсдэг вэ гэдгийг мэдэрч чадвал үнэ асуудал биш. Чи худалдан авагчийнхаа тархинд өөрийн эерэг орон зайг эзэлсэн л бол хүссэн үнээ тулгах боломжтой” гэдгийг Stephen Kreppel онцолсон юм.

Харин өнөөдөр байдал ямар байгаа талаар хэд хэдэн жишээ дурдаж болно. Тухайлбал, Говь компани нь нэг ноолууран цамц үйлдвэрлэхэд дунджаар 50 ам.доллар зарцуулдаг байна. Харин худалдах үнэ нь 100 ам.доллар. Гэтэл гаднын аль нэг брэндийн ноолууран цамцны зардал адилхан л 50 ам.доллар бол худалдах үнэ нь 300 ам.доллар. Эндээс харахад Монгол Улс өөрийн үнийг худалдан авагчдад санал болгох биш тэдний санал болгосон үнээр бүтээгдэхүүнээ борлуулж байгаа хэрэг аж.

## Бид юугаараа бахархдаг вэ?

Өнөөдөр Монголын бахархал юу вэ гэдгээ бид мэдэхгүй байх шиг. Зүгээр л зурагтаар үндэсний бахархал гэж ярьдаг боловч чухам юуг хэлэхээ мэддэггүй. Германчууд “Манай үйлдвэрлэсэн бүх зүйл

хамгийн чанартай. Наад зах нь манай BMW машиныг мэдэхгүй хүн байхгүй дээ” гээд онгирах, үндэстнээрээ, одоогоороо бахархах зүйл тэдэнд бий.

Харин монголчуудад юу байгаа билээ. Нөгөө л нэг найман зууны тэртээх Чингисээрээ омогшиж, түүний удам гэдгээрээ бахархсаар суух уу. Магадгүй зарим нэг хүний бодлогоор үндэсний бахархал нь хэт туйлширсан үндсэрхэг үзэл буюу гаднын хүн харахаараа доромжлох, гар хүрэх шалтаг болсон гэх. Ямар сайндаа Их Британийн The Guardian сонинд нийтлэгдсэн нийтлэлд “Нацизмын шинэ давалгаа итгэж боломгүй газар үүрлээд байгаа нь, Монгол Улс. Хэт үндсэрхэг үзэлтнүүд эдийн засаг нь сүйрч ядуурсан газар төрөн гарч, гаднынхан руу чиглэж байна. Тэднийг шүүмжлэгчид энэ бол ердөө л гэмгүй иргэд рүү дайрч довтолж байгаагаа далдлах гэсэн өнгөлөн далдлалт, шалтаг гэж шүүмжилж байна” гэжээ. Энэ бол үндэстнээрээ бахархах ойлголт хараахан биш болов уу.

Харин бид өөрийн орны олон улсад танигдах нэр хүнд, бараа бүтээгдэхүүн зэрэг олон сайхан зүйлээрээ бахархаж, нүүр бардам, цээж тэнэгэр алхах нь жинхэнэ “Үндэсний бахархал” юм. Брэнд энэ боломжийг бий болгодог ажээ. Товчхондоо монгол хүн өөрийн эх орноороо бахархах бодит зүйлтэй болно гэсэн үг. Алт, мөнгөний сорьцыг хараад хэн ч хэзээ ч эргэлздэггүй шиг брэнд ухагдахуун нь хүмүүст ямар ч эргэлзээгүйгээр сайхан гэх ойлголтыг л төрүүлэх учиртай. Монгол Улс чухам ийм брэндийг бий болгох ёстой аж. Уг нь тийм ч хэцүү ажил биш гэсэн. ■

КОМПАНИЙН ТҮҮХ

## ҮНДЭСТЭН ДАМНАСАН ХУДАЛДААНЫ БИЗНЕС ХҮРТЭЛ

Өдгөө 20 насныхаа ойг угтаж буй “Номин” холдинг группын үндэс суурийг ийнхүү Шагдарсүрэн гурван хүү, эхнэрийнхээ хамтын ухаанаар, өргөө гэртээ, өөрт байгаагаараа эхлүүлсэн нь энэ.

Б.ЭНХМАРТ

20 нас гэдэг хүнээр бол амьдралд хөл тавьж байх эрч хүчтэй дүрэлзсэн үе юм. Харин худалдааны салбарт 20 жил гэдэг асар их хугацаа, алдаа оноо, арвин их туршлага хуримтлагдсан он жилүүд аж. Монголын шилдэг татвар төлөгч, шинэ цагийн худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээг үүсгэн байгуулагч “Номин холдинг” группын 20 жилийн ой энэ онд тохиож буй.

### Оёдлын машинаас эхэлсэн түүх

Засгийн газрын 20 дугаар тогтоол олон айлыг хоосон хонуулж, цөөнгүйг нь өөрсдийн хүч хөдөлмөрөөрөө амьдралын төлөө нойр хоолгүй зүтгэх шаардлага бий болгосон. Мөнгөний ханш навс унаж, хоосон шахуу лангуун дээрх цөөхөн нэр төрлийн барааны үнэ цаг, минутаар нэмэгдэж, амттан битгий хэл идэх хоол нүдний гэм болох дээрээ тулсан гэдэг. Тухайн үед А.Шагдарсүрэнгийн хань Р.Содномын санаанд багтаж, нүдэнд нь туссан зүйл бол онгорхой цоорхойгоо цойлдож, олон арван жил хувцас оёж өмссөн оёдлын машин нь байж. Тиймдээ ч хүн болгон ганзагын наймаанд хөл нийлүүлж, хоногийн хоолны эрэлд зүтгэж эхлэхэд тэднийх эсгэж, оёж эхэлсэн байна. Эхлээд хувцас хунархан оёж, түүнийгээ хямд үнээр өгдөг байсан ч энэ нь амьдралд дэм болохдоо тааруу байв. Тиймээс Шагдарсүрэн хүмүүс юу сонирхож, юуг хамгийн их худалдан авч байгааг судлахаар гарлаа. Тэрбээр санаандгүй шахам валютын

дэлгүүрээр орж, худалдагчтай нь санал бодлоо солилцсон нь түүний амьдралд томоохон өөрчлөлт орохын эхлэл байв. Учир нь валютын дэлгүүрүүдээр АНУ, Европ, Япон зэрэг гаднын үйлчлүүлэгчид ихэвчлэн ирдэг бөгөөд тэд монгол үндэсний хэв маяг шингэсэн хувцас, бэлэг дурсгалыг мөнгө хайрлалгүй авдгийг сонсоод авлаа. Тийнхүү тухайн үед бараан зах, бөс барааны дэлгүүрүүд, бас хараахан дампуурчихаагүй байсан оёдлын том үйлдвэрүүдийн савхи, даавууны хаягдал, өөдөсний эрэлд гарлаа.

Хөөрөгний даалин, үнэг, булга, тарваганы арьсан малгай, бэлэг дурсгалын зарим зүйл, хээ, угалз, шаглаа нь таарсан үндэсний дээл, цамц, цүнх, уут оёж эхэллээ. Гаднынхан гэлтгүй монголчууд ч уран нарийн хийцтэй, донжтой бараануудыг худалдан авч байв. Өдгөө 20 насныхаа ойг угтаж буй “Номин” холдинг группын үндэс суурийг Шагдарсүрэн ийнхүү гурван хүү, эхнэрийнхээ хамтын ухаанаар, өргөө гэртээ, өөрт байгаагаараа эхлүүлсэн нь энэ. Улмаар 1992 оны долоодугаар сарын 11-нд “Номин-5” ХЭАА улсад данстай байгууллага болов.

### Худалдааны салбарын соёлыг тэд бий болгосон

Монголд худалдааны салбар үүсч хөгжөөд даруй 90 гаруй жил болж буй ч тус салбарыг ном дүрмээр нь хөгжүүлсэн анхдагч бол “Номин”-

гийн тав гэдэгтэй олон хүн санал нийлдэг. Тэд дуу, хөгжим бичлэг хувилж, олшруулж улмаар электрон барааны худалдааг нэвтрүүлсэн юм. Тухайн үеийн монголчууд гэртээ, найз нөхөддөө бэлэглэх зориулалтаар электрон барааг ганц нэгээр нь авчирдаг байсан үе. Харин Шагдарсүрэнгийн дунд хүү Баярсайхан шүтэн бишрэгч Майкл Жексоны тоглолтыг үзэхээр Сингапур яваад ирэхдээ цаг, зургийн аппарат, камер, хөгжим тоглуулагч зэргийг худалдах зорилгоор авчирснаар Монголд электрон барааны худалдаа, ахуйн соёл хөгжих эхлэлийг тавьсан гэдэг.

1994 оны нэгдүгээр сарын 14-нд Улаанбаатарын III хорооллын аж үйлдвэрийн барааны 60 дугаар дэлгүүрийн үүдний давчуухан талбайд лангуу байрлуулан, Сингапураас авчирсан электрон бараагаа зарж эхэлсэн нь өнөөдрийн “Номин” электрониксийн эхлэл байв. Баярсайхан хэрэглэгчдэд тоос сорогч, хөргөгч, угаалгын машин, телевизор зэрэг орчин цагийн цахилгаан барааг хэрхэн ажиллуулж, ашиглах талаар өдөржин зогсоогоороо зөвлөгөө өгдөг байсан аж. Энэ бизнес нүдээ олсон ашигтай салбар болон хөгжиж, тэд удалгүй “Номин” электрон барааны тасагтай болжээ. 120 мянгатын Дугуй дэлгүүрийн хэд хэдэн лангууг түрээсэлж, анхны электрон барааны дэлгүүр үүд хаалгаа нээлээ. Мөн түүнээс хэсэгхэн хугацааны дараа буюу 1995 оны арванхоёрдугаар сард нийслэлийн I хорооллын “Саппоро”-гийн ард дэлгүүр нээн ажиллуулсан нь ▶▶



БГД-ийн III хорооллын үйлчилгээний 2-р төвийг 1998 онд нээв

одоогийн “Номин Холдинг” компанийн салбар сүлжээ дэлгүүрийн үүсэл байжээ.

## Өмчтэй болж, шудрага өмч хувьчлалыг үлгэрлэв

Бараагаа нэг дор төвлөрүүлж, “Бүгдийг нэг дороос” гэх уриа бүхий цогц төв бий болгох нь худалдан авагчдын цаг, завьг хэмнэхээс гадна олон хүнийг ажлын байртай болгож, амьдралд нь нэмэр болно гэдгийг тэд ухамсарлаж байв. Гэвч бүгдийг нэг дор төвлөрүүлэхэд томоохон байр хэрэгтэй байсан бөгөөд түүнийгээ хэрхэн олж авахыг судалж эхэлсэн байна.

1996 оны арваннэгдүгээр сарын 22-ны 15.00 цагт Төрийн Өмчийн Хороо / ТӨХ/-ны анхны нийтийн дуудлага худалдаа зохион байгуулахад Шагдарсүрэн, хүү Баярсайханы хамт оролцож, Энхтайвны өргөн чөлөө, нэгдүгээр 40 мянгатын тавдугаар байрны залгаа хоёр байр болох 260 ам метр талбай бүхий байрыг 145

орчим сая төгрөгөөр худалдан авч, өөрийн гэсэн анхны өмчтэй боллоо. Энэ нь олон хүнд шинэ сэдэл, санаа өгч, Монголд төрийн өмчийг дуудлага худалдаагаар шударга хувьчлах ажлын эхлэл болсныг ТӨХ-ны мэргэжилтнүүд онцолдог.

Дуудлагаар худалдан авсан объектынх нь өмчлөгчийн эрхийн 0001, 0002 тоот гэрчилгээг “Номин трейд” ХХК-д олгосноор тус байранд электрон барааны анхны том дэлгүүр болох “Нэйшнл Панасоник” төв байгуулагджээ. Тэгээд ч зогсохгүй үүднийх нь умгар зайд лангуу нээж байсан 60 дугаар дэлгүүрийн талбайн баруун талыг ч дуудлага худалдаагаар худалдан авлаа. Ингэснээр III хороолол дахь электрон барааны төв үүд хаалгаа нээв. Тухайн үед “Номин-5” ХЭАА-г худалдаа үйлчилгээний Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болсныг зарлаж байв. Электрон барааны худалдаагаар Монголыг байлдан дагуулж эхэлсэн тус компанийнхан хүнсний худалдаа ирээдүйд ихээхэн ашиг авчрахыг

тооцоолж, 1997 онд 56 дугаар дэлгүүрийн барилгыг мөн дуудлага худалдаагаар 320 сая төгрөгөөр худалдан авч, Монголын худалдааны салбарын акул гэгдэх болов. Ийнхүү Монголын худалдааны салбарт шинэ салхи сэвэлзүүлсэн “Номин”-гийнхон нийслэл төдийгүй хөдөө, орон нутагт байгууллага, хөдөлмөрчдийн захиалгаар электрон барааг “Монгол шуудан” компанитай хамтран илгээж, худалдааны цар хүрээгээ тэлсээр байв. Тэгээд ч зогсохгүй Өмнөд Солонгосоос, ОХУ руу автомашин реэкспортоор борлуулж, Казахстан, Герман, БНХАУ-аас хүнсний бүтээгдэхүүн, барилгын материал импортлож, ард иргэдэд түгээхээс гадна бусад худалдааны газруудад нийлүүлж, гар утас анх импортлож, персонал компьютер угсарч, суурилуулах, худалдаалах, компьютерийн дотоод сүлжээ тавих ажлын эхлэлийг ч тэд тавив.

2005 онд “Номин” агуулах худалдааны төв нээсэн нь бас л анхдагч байв. Тэд худалдаа үйлчилгээний олон дэвшилттэй шинэ зүйлийн эхлэлийг тавьж, бусдад үлгэр дуурайл болсоор байлаа. Гэр бүлээрээ эхлүүлж байсан оёдлын цех, мод, төмөр эдлэлийн үйлдвэрлэл, реклам чимэглэлийн баазын хүрээнээс хальж, одоогийн “Эрдэнэт” хивсний үйлдвэрийн эзэд болов.

1998 онд 170 хүний суудалтай дууны стерео кино театр нээсэн нь залуучуудын урлаг, соёл, боловсролын хувьд том хөрөнгө оруулалт байв. “Номин супермаркет” сүлжээ дэлгүүрийг бий болгож, Япон улсын Мацушита Электрик Корпорацийн “Нэйшнл Панасоник”-ийн худалдааны төв, Электрон барааны засварын төв, Швейцарь улсын Рояль фирмийн зайрмагны кафе зэргийг нээсэн нь гаднын соёлыг Монголд нэвтрүүлсэн үйл явдал байлаа. Ийнхүү хувцас эсгэж, оёхоос эхэлсэн гэр бүлийн худалдаа үндэстэн дамнансан бизнес болтлоо өргөжиж, өдгөө худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга, санхүү даатгалын чиглэлийн 12 охин компанитай, нийслэл, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дорнод аймагт “Номин” сүлжээ 21 дэлгүүртэй, 4000 гаруй ажилтантай, шилдэг татвар төлөгч групп болон өргөжиж, дараагийн амжилт өөд тэмүүлсээр. ■

# БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт Та бүхэнд “Номин Холдинг” Компанийн 20 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлбэ.

Номингийнхон хэрэглэгч түншүүдээ хүндэтгэн дээдэлж, зорьсон бизнесээ дээд зэргийн чанар хурдтайгаар эрхэлдэг, эх орныхоо хөгжил дэвшилд бодитой хувь нэмрээ оруулдаг, олон улсын хэмжээнд үйл ажиллагаа нь түгсэн хөгжингүй манлайлагч компани болох эрхэм зорилготойгоор ажиллаж ирлээ.

Номингоор овоглогосод бид бизнесийн гараагаа таван гишүүнтэй халуун ам бүлийн хүрээнд гэрийн үйлдвэрлэлээр эхэлж байхдаа өнөөдрийн энэхүү өндөрлөгт хүрнэ гэдгийг төсөөлөөгүй хэдий ч ихийг хийж бүтээх хүсэл зорилго, тэмүүлэл бидний сэтгэлд дүүрэн байсан юм.

ЗОРИЛГО, ТЭМҮҮЛЭЛ, ЗҮТГЭЛ-ийг өөрсдийн бизнесийнхээ “Тулгын гурван чулуу” болгож чадсанаараа бид өдрөөс өдөрт өргөжин тэлж, өөдлөн дэвжсээр байна. Дэлхийн энтэй сэтгэж, хийж бүтээх гэсэн бидний чин хүсэл зорилго өнөөдөр биелэлээ олсоор, амжилттайгаар урагшилсаар байна.

Манай компанийн үндэс суурь 1992 оны долоодугаар сарын 11-нд “Номин-5” Хувиараа Эрхлэх Аж Ахуй (ХЭАА) нэртэйгээр байгуулагдаж байсан бол 1996 оны нэгдүгээр сарын 22-нд “Номин Трейд” ХХК, 2002 оны тавдугаар сарын 28-нд “Номин Холдинг” ХХК болж үйлдвэрлэл, худалдаа, барилга, санхүү, даатгалын чиглэлээр зах зээлд өрсөлдөх чадвар бүхий 12 охин компани, 4000 гаруй ажиллагсадтай болтлоо өргөжин, сард давхардсан тоогоор 700 мянга гаруй хувь хүн, олон зуун байгууллагад үйлчилж Монгол улсын хөгжил цэцэглэлт, нийгмийн сайн сайханд бодитой хувь нэмрээ оруулдаг үндэсний шилдэг компаниудын нэг болж хөгжиж байна.

Манай улсын эдийн засаг сүүлийн 15 жилд эрчимтэй өсч нэг хүнд ногдох ДНБ 1996 онд 512 ам.доллар буюу бага орлоготой орон гэж ангилагдаж байсан бол ахисаар одоо 3700 ам.доллар буюу долоо дахин өсч, дундаж орлоготой орон гэж ангилагдах боллоо. Өнгөрсөн онд Монголын эдийн засаг 17,5 хувиар өсч, дараа жилүүдийн төлөв байдал үүнээс ихээхэн өндөр байхаар байгаа нь бизнес эрхлэгч бидний хувьд ирээдүйдээ итгэл дүүрэн, урамтай.

Номин Холдинг компанийнхан дотоодынхоо төдийгүй дэлхийд тэргүүлж яваа Ази номхон далайн орнууд, АНУ, Европын холбооны улсуудын нэрд гарсан олон фирмтэй харилцаж, туршлагыг нь судлан нэвтрүүлж, шилдэг брэндийн бараа бүтээгдэхүүнийг монголынхоо хэрэглэгчидэд цаг алдалгүй хүргэж байдагтаа сэтгэл ханамжтай байдаг юм. Хэрэглэгч “ТАНЫ ТӨЛӨӨ 20 ЖИЛ” ойн арга хэмжээний хүрээнд Номинчууд бид өнгөрснөө эргэн харж, хийж бүтээсэн болон одоогийн ажил үйлсээ дүгнэн цэгнэж, ирээдүйдээ төсөөлөн баримжаалж байна.

Бид жилдээ 25 тэрбум төгрөг улсын төсөвт татвар, шимтгэлээр оруулдаг боллоо. Монгол улсынхаа хөгжил дэвшилд хариуцлагатайгаар оролцоод зогсохгүй дэлхийн бусад шилдэг компаниудтай эн зэрэгцэн нэг тавцанд алхаж улам урагшлах зорилго бидэнд бий. Монгол Улсын дөрвөн удаагийн Шилдэгийн Шилдэг Компани, Нийслэл хотын дөрвөн удаагийн Шилдэг Аж Ахуйн Нэгжээр шалгарч 2008, 2011 онд Ази Номхон Далайн Орнуудын ХАҮТ-уудын Холбооны “Шилдэг компани”, 2011 онд Ази Номхон Далайн Орнуудын Жижиглэн Худалдаа Эрхлэгчдийн Холбооны “Шилдэг Үйлчилгээтэй Компани” зэрэг шагнал, өргөмжлөл хүртсэн нь олон улсын хэмжээнд үйл ажиллагаа нь түгсэн хөгжингүй манлайлагч компани болох зорилго тодорхой хэмжээнд биелж байгаагийн нотолгоо гэж үзэж байна.

Бидний ололт амжилт бол бадрангүй тэмүүлэлтэй, ёс суртахуунлаг, бүтээлч Номинчуудын маань сэтгэл зүтгэлийн үр шим, нийт хэрэглэгч үйлчлүүлэгчид, дотоод, гадаадын харилцагч түншүүдийн маань бидэнд хүлээлгэсэн итгэлийн үр шим юм. Өнөөдөр бид дотоодын 5000 гаруй жижиг, дунд үйлдвэрлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гадаадын 400 орчим харилцагч, түншүүдтэй хамтран ажиллаж байна.

“Номин Холдинг” Компанийнхаа 20 жилийн ойг тохиолдуулан үе үеийн Номинчууддаа, тэдний гэр бүлийхэнд, биднийг дэмжин тусалж байдаг эрхэм түншүүд, үйлчлүүлэгчиддээ талархалаа илэрхийлж дахин баяр хүргэе.

“Номин Холдинг” Компанийн Ерөнхийлөгч

Ш.БАЯРСАЙХАН

## ХҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ЦӨМ БАГТСАН

ЭРҮҮЛ МЭНД


## ХАРШИЛ ДЭЛХИЙ НИЙТИЙН ӨВЧИН БОЛЖ БАЙНА

Дэлхийн өнцөг, булан бүрт харшлын эсрэг эм, бэлдмэл, тосон түрхлэг хамгийн эрэлттэй бизнес болж, сая сая хүн өвчин, зовиураа дарахын тулд халаасаа хоосолж байна.

Х.АНАНД

Хорвоо, ертөнц дээр хүнд харшил өгдөггүй юм гэж ховор боллоо. Ус, агаар, нар, салхи, хувцас, хоол хүнс гээд орчин тойронд байгаа бүхнээсээ олон зуун сая хүн харшил авч, шаналж, зовж байна. Саяхныг хүртэл харшлыг хамрын, ургамлын, шарилжны гэсэн цөөхөн ангиллаар төсөөлж, мэддэг байв. Гэтэл хэдхэн жилийн дотор өмнө нь байсан бүгдээсээ харшилж эхэллээ. Дэлхийн өнцөг, булан бүрт харшлын эсрэг эм, бэлдмэл, тосон түрхлэг хамгийн эрэлттэй бизнес болж, сая сая хүн өвчин, зовиураа дарахын тулд халаасаа хоосолж байна.

Амьдралын буруу хэвшил, хими, физикийн, цөмийн гэх мэт олон зуун туршилт, агаарын бохирдол, хуурайшилт, цөлжилтийн улмаас хүн төрөлхтөн байгаль дэлхий, амьдрах орчинтойгоо дасан зохицох чадваргүй, дархлаагүй болж харшил гээчид дарлуулж буйг эрдэмтэн, судлаачид баталж байна. Өдгөө дэлхийн долоон тэрбум гаруй иргэний 40 орчим хувь нь ямар нэг харшлын өвчтэй, тэдний 10 гаруй хувь нь эмчлэгддэггүй харшлаар өвчилсөн байдаг аж. Харшлын өвчнөөр өвчлөгсдийн 24-30 хувийг ургамлын тоосны харшил эзэлж байгаа бол хоол хүнснээс 15-20 хувь, эм тарианаас 20-25 хувь нь харшил авч байна. Харамсалтай нь уг өвчин удамшдаг бөгөөд өдөр ирэх тусам залуужиж байгааг эмч, мэргэжилтнүүд онцолж байна. Харин манай улсын хувьд нийт хүн амын 50-52 хувь буюу таван хүн тутмын нэг нь ямар нэг харшилтай, харшлын төрлийн эмгэгтэй байгааг ЭМЯ-наас өнгөрсөн дөрөвдүгээр сард зохион байгуулсан “Харшлаас урьдчилан сэргийлье” арга хэмжээний үеэр мэдээлж байсан. »



► **Санаанд багтамгүй, эмчлэгдэх боломжгүй, зарим харшлын түүхийг хамтдаа сөхье.**

## Усанд хүрвэл тууралт гарна

Дэлхий дээр усны харшилтай 23 сая хүн байдаг. Усны харшилтай хүмүүс голчлон усыг буцалгаж хэрэглэдэг байна. Уг өвчнөөр өвчилсөн хүмүүс усан санд сэлэх, усанд орох, хөөстэй усанд хэвтэх талаар бодохоосоо ч айдаг. Тэр бүү хэл бороонд норох ч эрхгүй. Хэрэв өөрийн биеийн бүтцэд тохирсон уснаас өөр ус дуслын төдий л биед нь хүрвэл улаан тууралт гарч, тэсэхийн аргагүй загатнадаг аж. Тэд ус уухын тулд уруулдаа зузаан гэгч нь тос түрхэж, болгоомжтой залгилдаг гэнэ.

## Сексийн харшил

Сексийн хамтрагчийнхаа үрийн шингэнээс харшилсан маш цөөн тохиолдол ДЭМБ-ын хар дансанд бүртгэлтэй байдаг аж. Харшлаа маш түргэн хугацаанд дарж, эдгээхгүй бол амь насанд нь аюул учруулдаг байна.

## Ном уншихыг хориглоно

Тэдний эргэн тойронд мод, модон тавилга, модны хольцтой ямар нэгэн юм байгаа л бол модны харшилтай хүмүүсийн дотор нь муухай оргиж, толгой нь өвддөг байна. Тэр ч бүү хэл ийм харшилтай хүмүүс ном унших хориотой байдаг аж. Учир нь номын гол материалыг модны үртсээр хийдэг. Гэхдээ тодорхой дэглэм барьж, түүнийгээ мөрдөж чадвал өвчин нь хүндэрдэггүй гэсэн.

## Хүүхдэдээ хүрэх эрхгүй

Жоанне Маки хэмээх нэгэн эмэгтэй маш ховор тохиолдох харшилтай нэгэн ажээ. Тодруулбал анхны хүүхэд болох Жеймсээ төрүүлээд удаагүй байхад түүний нуруу, хөл, гар цээж гээд бүх бие нь өвчин орсон байна. Хүүхдээ ч тэвэрч чадахгүй болсон эмэгтэй хувцаснаасаа харшил авч хэмээн бодож сорил өгөхөд, төрүүлсэн хүүхдээсээ харшил өгч байна хэмээн эмч нар оношилсон гэнэ. Улмаар харшлын эмчилгээ хийж, хүүхдээ нэг ой хүртэл аль болох хол байхыг зөвлөсөн байна. Түүний энэ харшил хүүхдэд нь удамших эсэх нь одоогоор тодорхойгүй байгаа юм.

## Долгион мэдэрвэл хавдана

Энэ нь харшлын өвчлөлийн хамгийн залууд орж буй төрөл бөгөөд одоогоор долгионы өвчин хэмээн нэрийдээд байгаа аж. Уг өвчнөөр өвчлөгсдийн 80 орчим хувь нь 13-18 насны хүүхэд, залуус бөгөөд тэдний ойролцоо радио, гар утас, шарах шүүгээ, утасгүй интернэт зэрэг хүн төрөлхтний салшгүй хэрэглээ болсон орчин үеийн технологийн аль нь ч байх ёсгүй. Учир нь энэ өвчнөөр өвчлөгсдийн зовхи хавдаж, юм харах аргагүй болдог байна.

## Нарнаас зугтагсад

Дэлхий дээрх харшлын өвчтэй иргэдийн найм орчим хувийг нарны харшлын эмгэг эзэлдэг байна. Тэгвэл энэхүү өвчний шинж тэмдэг сүүлийн жилүүдэд улам хүндээр илрэх болсон аж. Тухайлбал, дэлхийн хамгийн халуун бүсийн гэгдэх Персийн булан, Улаан далайн орчмын зарим иргэн нарны гэрэлд хэдхэн минут байх төдийд л арьс нь түлэгдсэн мэт болж, цэврүүтдэг байна. Цэврүү нь өдөр ирэх тусам томорч, улам шаналгаатай болдог бөгөөд, нарны харшлын эсрэг эм, бэлдмэл, тосон түрхлэгийн аль нь ч нэмэр болдоггүй аж. Олон хоног зовсны эцэст уг цэврүү маш том сорви болон үлддэг байна.

## Халууныг хүсэгчид

Дэлхий дээр халуунаас дайжиж, сэрүүн, хүйтэн газар амьдрахыг хүссэн зуу зуун хүн байхад хүйтнээс харшиж, хамаг бие нь янгинан өвдөж, зовдог хүмүүс бас байна. Энэ өвчнөөр өвчлөгсдийн тоо сүүлийн жилүүдэд маш их дэлгэрч байгаа бөгөөд Монголд ч ийм өвчтэй хүн цөөнгүй байдаг байна.

**Монголд харшил хэмээх чимээгүй тахал хэрхэн газар авч байгаа талаар Арьсны өвчин судлалын үндэсний төвийн Арьс, гоо заслын тэргүүлэх зэргийн эмч Б.Оюунтай ярилцлаа.**

**-Харшил дэлхий нийтийн өвчин боллоо хэмээх мэдээлэл тасрахаа болилоо. Энэ өвчнийг улирлын чанартай гэдэг байсан ч одоо улирлаас хамаарахаа байсан гэх юм. Танай эмнэлэгт хандаж байгаа, хүмүүсийн дунд энэ төрлийн өвчлөл хэр их байна вэ?**

-Манайхаар үйлчлүүлж байгаа хүмүүсийн ихэнх нь ургамлын болон тоосны, эмийн харшил, писраз, экзим зэрэг өвчнөөр хандах нь их байна. Ялангуяа, сүүлийн үед улирлын чанартай хүйтний харшил нэмэгдсэн. Мөн хөлний мөөгөнцрийн халдвар авсан иргэд цөөнгүй хандах болсон. Эмчилгээний түүх, судалгааны ажлын тайлангаас үзэхэд 1970 онд харшил төдийгүй бэлгийн замын төрлийн өвчлөлүүдийг бүрэн дарсан байдаг. Харин харшлын өвчин манай улсад 1980-аад оноос, бэлгийн замын халдварт өвчин 2000 оноос иргэдийн дунд хурдацтайгаар тархаж эхэлсэн байна. Одоогоос таван жилийн өмнө харшлаар өвчлөгсдийн өвчлөлийг хамрын, ургамлын харшил зонхилж, цөөн тохиолдолд бусад харшлын гаралтай өвчин илэрч байсан бол өнөөдөр орчин тойронд байгаа бүх зүйлээс харшилж, өвчилдөг болж байна. Тэр бүүхэл хаана ч гэлээ төрүүлсэн хүүхдээсээ харшилж байгаа мэдээ гарч байсан. 2011 оны сүүлийн дүнгээр Монголын нийт хүн амын 52 орчим хувь ►

► нь харшлын гаралтай үрэвсэл, өвчлөлтэй болох нь тогтоогдсон. Гэхдээ үүний цаана судалгаа, оношлогоо, сорилд ороогүй олон зуун хүн байгаа. Харшил дэлхий нийтийн өвчин болж байна гэдэг үнэн.

**-Харшлын өвчлөл ихсэж байгаа нь юутай холбоотой юм бол?**

-Харшил бол соёл иргэншлийн өвчин. Хотжилт, соёл иргэншил, амьдралын хэв маяг, орчин өөрчлөгдөхийн хэрээр хүний бие махбодь иргэншилд дасан зохицох чадвар, дархлаагаа алдаж байдаг. Хэдэн зуун жилийн өмнө ургамлын тоос, гэрийн тэжээвэр амьтан байж л байсан. Тэр үед орчин тойрны бүгдээсээ харшил авч, өвдөж, зовоогүй өнөөдрийг хүргэсэн. Харин өнөөдөр бол хүмүүс тэднээс гадна олон зуун биет, техник, технологитой харилцаж, дасан зохицох чадваргүй болж эхэлж байна. Үүний илрэл бол учир нь тайлагдах, тайлагдахгүй олон зуун төрлийн өвчлөл юм.

**-Хүн орчин тойронтойгоо дасан зохицох чадвараа алдаж байна гэсэн үг үү?**

- Харшил буюу аллерги гэсэн нэр томъёог Австрийн хүүхдийн их эмч К.Пирке 1906 анх хэрэглээнд оруулсан түүхтэй. Тэрбээр энэ үгийг гадны нөлөөг бие организм “хурцаар” хүлээж авах гэж тайлбарласан байдаг. Харшил гэдэг нь хүний бие гадны хүчин зүйлд эмзэглэн хэт цочмог, хүчтэй хариу үзүүлж байгаа хэрэг юм. Хүний биед дархлааны тогтолцоо гэж бий. Үүний байгалийнх нь үндсэн зориулалт нь гаднаас орж ирж байгаа аливаа халдварын эсрэг тэмцэж, хүний биеийг эрүүл байлгах. Гэтэл хүний бие махбодийн дархлааны тогтолцоонд өртөж байдаг халдварын хүчин зүйлийн хэмжээ ихсэх тусам дархлааны хүчин чадал суларна. Өөрөөр хэлбэл, гурван нянг эсэргүүцэх чадвартай бие рүү байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гурван зуун нян дайрдаг болсон гэсэн үг. Өдөр ирэх тусам хүний дархлаа суларч, иргэнших хэрээр сул дорой болж байна.

Манайх харьцангуй ачаалалтай байдаг эмнэлэг. Сүүлийн гурван жилд ачааллаа бүр ч дийлэхгүйд хүрээд байна. Учир нь өмнөх жилүүдэд хавар, намрын улиралд харшлын өвчлөл ихэсч, иргэд манайхыг зорьдог байсан бол одоо жилийн дөрвөн улиралд, өдөр бүр ирээд онош тодруулахаар урт дараалал үүсгэж байна.

**-Бага насны хүүхэд, тэр тусмаа нярай хүүхэд харшлаар өвчлөл нь их байна гэж байсан?**

-Тийм шүү. 2007 оноос хойш хүүхдийн тэр дундаа нярай хүүхдийн өвчлөл огцом нэмэгдсэн байдаг. Эхээс төрөхдөө л харшлаас эхлээд элдэв өвчлөлтэй төрж буй нь идэж ууж, өмсөж, зүүж, хэрэглэж буй бүхнээс нь хамааралтай. Хүүхэд эхээс төрөхдөө харшилтай төрж байгаагийн гол шалтгаан нь архи, тамхи, амьдралын буруу

хэвшил, эхийн эрүүл мэндтэй холбоотой. Хүмүүс хүүхдээ төрөнгүүт гаднын том брэндийн элдэв хувцас өмсгөж, үнэтэй тос, шампунь хэрэглүүлнэ гээд насан туршид нь харшилтай болгох нь их байна.

**-Харшлын хэчнээн хэлбэр байна вэ. Зарим нь эмчлэгдэх боломжгүй гэх юм?**

-Харшил бий болгогч 5000 гаруй төрлийн бодис байдаг нь тогтоогдоод байна. Гэхдээ энэ нь эцсийн тоо биш юм. Зөвхөн манай иргэдийн зонхилон өвдөөд буй ургамлын тоосны харшил гэхэд дотроо 30-40 төрөл байх жишээтэй. Жишээ нь, модлог, үет, хогийн гээд 30 гаруй төрлийн ургамал харшил үүсгэдэг. Харшил нь арьсны, амьсгалын гэсэн хоёр шинж тэмдэгээр илэрдэг. Амьсгалын замаар илэрдэг харшил нь илүү аюултай. Харшил өвчнийг эрт оношилж, эмчилгээ хийж чадвал эмчлэгддэг. Харин иргэд бүр болохоо байгаад, мутацид орж, хүндэрсэн хойно нь эмчид ханддаг. Ийм үед үрэвслийг дарах, тогтворжуулах эмчилгээ хийхээс өөр аргагүй. Харшлаа эмчлүүлэхгүй удаан явбал хүнд хэлбэрийн астам болдог. Мөн арьсан дээр цэврүүтэй тууралт гарч, аминд аюул учруулдаг. Харшилтай хүмүүсийн 80 хувь нь 20 хүртэлх насандаа харшилтай болсон байдаг бол үлдсэн хувь нь насанд хүрсэн хойноо харшлаар өвчилдөг. Тиймээс хүүхэд, өсвөр үеийн дунд хамгийн түгээмэл тохиолддог гэж хэлж болно. Манай эмнэлгээр үйлчлүүлэгсдийн 70 орчим хувь нь 18-35 насны залуус байна.

**-Манайд харшлыг хэрхэн оношлодог юм бэ. Сорил тавиулснаар юунаас харшил авснаа тодорхой мэдэх боломжтой юу?**


-Манайд 40-өөд төрлийн харшил оношлох оношлуур байна. Сорил тавиулснаас ургамлын тоосны, амьтны үс, ноосны, үйлдвэрийн, гэр ахуйн тоосны харшил, хүнсний бүтээгдэхүүний харшил гэх мэт төрөл төрлөөр нь оношлох боломжтой.

**-Харшлын урьдчилсан сэргийлэх болоод өвчлөлийн дараах эмчилгээний талаар манай уншигчдад зөвлөгөө өгөөч?**

-Хоолны дэглэм хамгийн чухал. Нэгдүгээрт, амин дэм сайтай, тэжээллэг хоол хүнс хэрэглэх ёстой. Мөн зарим хүнсний бүтээгдэхүүн харшлыг сэдэрээдэг тал бий. Тухайлбал, перцтэй хоол, амтлаад удаан хадгалсан хоол, айраг буюу исгэлэн бүтээгдэхүүнүүд, чипс, газтай ундаа, жимс, самар гээд харшил сэдэрээдэг олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн бий. Бид хоолны дэглэм бичиж өгөхөөс гадна урьдчилсан сэргийлэх эмчилгээ буюу өвөрмөц дархлаа тогтоох эмчилгээ хийдэг. Жишээ нь, ургамлын тоосны харшлын өвөрмөц дархлаа тогтоох эмчилгээ гэж хийдэг. Энэ эмчилгээнд явдаг хүмүүст хүндрэл бага байдаг. Манай судалгаагаар бол урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн 80 хувь нь уг өвчнөөс айхгүй амьдарч чаддаг. ■

## БИЗНЕСИЙН ЗАВСАРЛАГА

## ТА ЯМАР НОМ УНШИЖ БАЙНА ВЭ?




## Капитализмын танд хэлдэггүй 23 зүйл

Б.АРВИНБАЯР

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хувийн хэвшил, инновацийн бодлогын хэлтсийн дарга/

-Солонгосын эрдэмтэн Ха Жон Чанг Капитализмын танд хэлээгүй 23 зүйл бичсэн нь олон хүний анхаарлыг татжээ. Манай улс сүүлийн жилүүдэд эдийн засгийн өндөр өсөлттэй байгаа ч хүндээ хүрч байна уу, үгүй юу гэдэг дээр эргэлзэж, арга замыг нь хайх болсон. Жишээ нь, улс орон бүрт нэг хүнд ногдох ДНБ харьцангуй байдаг. Хэдий ДНБ өндөр ч өгөөж нь муу байгааг хүн бүхэн шүүмжлэх болсон. Тэгвэл энэ номонд хөгжлийн эдийн засаг гэж юу юм, түүнийг улс орнууд хэрхэн хөгжүүлдэг талаар дэлгэрэнгүй бичсэн. Ерөнхийдөө хөгжлийн эдийн засгийн зарчим, түүний хөгжлийн загварыг улс орнуудад хэрхэн хөгжүүлдгийг жишээтэй харуулсан байгаа. Манай эдийн засагчид, энэ чиглэлээр сурч буй оюутан, залуучууд энэ номыг заавал унших хэрэгтэй. Тун удахгүй манай Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны хэсэг залуус хамтарч тус номыг монгол дээр орчуулан гаргах гэж буй таатай мэдээг дуулгая. Тэр үед эх хэлээрээ хүн бүхэн унших боломжтой болох юм.



## Баялгийн үндэс нь юу вэ

Б.САЙНБАЯР

/"CEO" клубын гүйцэтгэх захирал/

-Chuck Bentley гэх эрдэмтэн зохиолч библди суурьтай дэлхийн ард түмэн хувийн санхүү, баялгаа хэрхэн арвижуулахыг номондоо бичсэн ухааныг хэрхэн удирдах талаар илтгэл тавьдаг. Амьдралын гол үндэс нь ус, агаар, нар билээ. Тэгвэл энэ бүхний нийлбэрээр бүтдэг модоор хүний амьдралын баялгийг үндсийг харуулж буй юм. Өнөөдөр XXI зуунд хүн бүхэн баялгийн төлөө хөөцөлдөж байна. Энэ дэлхий дээр хоёр төрлийн мод байдагтай адил хоёр төрлийн хүн байдаг. Үндэс нь би бодолтой, мөнгөнд дуртай, зугаа цэнгэлд хайртай хүний амьдралын мод нь цэцэглэдэггүй. Ингэснээр шуналтай, худал ярих, материаллаг сэтгэлгээ, атаа, жетөөч, амьдралдаа итгэлгүй болдог. Харин өгөх сэтгэлтэй, бусдын төлөө анхаардаг хүний баялаг үргэлж нэмэгдэж, бусдад хайраа өгч чаддаг билээ. Тэгэхээр өнөөдрийнхөө амьдралыг маргааш өөрчилж гэж бодож байгаа бол өөрийнхөө модны үндэстэй л ажиллах хэрэгтэй. Өнөөдөр Монголын баялаг нь Оюутолгой, Тавантолгой биш монгол хүний өөрийнх нь амьдралын итгэл үнэмшил, модны үндэс нь юм гэдгийг санаарай. Та энэ номыг уншсанаар бид дундардаг баялгийн хойноос хөөцөлдөх үү, дундардаггүй баялаг руу тууштай явах уу гэдгээ шийдэх болно.



## Израйлийн хөгжлийн гайхамшигт түүх

Д.БАТХУЯГ

/МУИС-ийн Технологи дамжуулах төвийн ахлах мэргэжилтэн/

-“Старт-ап үндэстэн буюу Израйлийн хөгжлийн гайхамшигт түүх” номыг уншигч танд санал болгож байна. Старт-ап үндэстэн номд 7,1 сая хүн амтай, 60 жилийн түүхтэй, байгуулагдсан цагаасаа хойш эргэн тойрон дайсангагч улсуудаар хүрээлүүлсэн, байгалийн баялаг байхгүй Израйль улсын хөгжлийн гайхамшигт түүхийг өгүүлдэг. Ингэхдээ Израйль дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч Япон, Хятад, Энэтхэг, Солонгос, Канад болон Англиас илүү олон тооны Старт-ап буюу гарааны компанийг амжилттай байгуулж, эдийн засгаа хөгжүүлж чадсан туршлагыг харуулсан байдаг. Хамгийн эрсдэлтэй бизнест хөрөнгө оруулалт хийдэг Вэнч Капиталын нэг хүнд ногдох хувь хэмжээгээ Израйль улс АНУ-аас хоёр дахин их, Европын Холбооны Улсаас даруй 30 дахин их болгож чадсан гайхамшигт нууцыг та эндээс тайлах болно. Тус улс нь АНУ-ын хөрөнгийн бирж дээр АНУ-ын дараагаар хамгийн олон технологийн чиглэлийн компанийг гаргаж чадсан нууц нь ч бий. Израйль улс зөвхөн компьютер, мэдээллийн нууц, холбоо харилцааны технологи төдийгүй эмнэлгийн багаж, төхөөрөмжийн олон патент, хоргүй технологи болон биотехнологийн салбарт дэлхийд тэргүүлдэг. Энэхүү жижиг улс шинэ санаа, шилдэг технологийн салбарт хэрхэн тэргүүлэгч улс болсон талаарх сонирхолтой, сэтгэл хөдлөм түүхийг уншиж, эрч хүч авахыг танд зөвлөж байна. ■



**НОГООН**  
ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ  
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**НОГООН  
ХӨГЖЛИЙН  
ТӨЛӨӨ**